

КОРОНАВИРУСИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ
СААРМАГЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2020.03.16

Нэг. Нөхцөл байдал

Дэлхийн ихэнх улс орныг дамнан тархаад буй коронавирус (Covid-19)-ын хор, уршиг манай орны нийгэм, эдийн засгийн байдалд хүчтэй нөлөөлж эхлээд байна. Төсвийн болон валютын орлогын цөмийг бүрдүүлдэг нүүрс, зэсийн экспорт буурч, нүүрсний ачилт хэсэг хугацаанд зогсож, дэлхийн зах зээл дээр зэс болон бусад эрдэс түүхий эдийн үнэ, эрэлт буурч эхлээд байна. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож зарим нь түр зогсолт хийж байна. Энэ байдал цаашид үргэлжилбэл бараг 200-аад мянган хүн ажлын байргүй болохыг Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас мэдээллээ. Мөн төсөв, гадаад төлбөрийн байдал хүндрэх дохио ирж байна. Оны эхний хоёр сарын байдлаар төсөв 120.0 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, төсвийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 173.7 тэрбум төгрөгөөр буурлаа. Оны эхний нэг сард төлбөрийн урсгал тэнцэлийн алдагдал 277.0 сая ам.доллар болсон бөгөөд энэ хэмжээ гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр зэрэгтэй уялдан өсөн нэмэгдэх дүр зураг ажиглагдаж байна. Эдгээр хүндрэлүүд улам даамжирвал сүүлийн жилүүдийн төсөв, мөнгөний бодлогын үр дүнд бий болсон хязгаарлагдмал мөнгө, валют, төсвийн нөөцийг барагдуулахад хүргэх эрсдэлтэй билээ.

Гагцхүү Засгийн газар, Сангийн яам, Монголбанк үндэсний аюулгүй байдлыг хангах хэмжээний санхүүгийн нөөцийг хадгалан авч үлдэх стартеги зорилтоо хэрэгжүүлж чадна гэдэгт итгэлтэй байна. Эдийн засгийн зарим салбарын зогсонги байдлын улмаас зээлийн олголт саарч, зээлийн эргэн төлөлт удааширч байна. Монголбанк санхүүгийн хэрэгслээр дамжуулан зохих хэмжээний санхүүгийн нөөцийг өөр дээрээ байлгах бодлого барьж буй нь санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, улс орны хэмжээнд яаралтай төлбөр гүйцэтгэх чадварыг бүрдүүлж буй хэрэг гэж үзэж байна. Үүнд аливаа улс төрийн нөлөө байж болохгүй юм.

Хөдөөгийн иргэдийн амьдралын голыг залгуулдаг ноолуурын салбарын ирээдүй ч бүрхэг байна. Арьс, шир сүүлийн хоёр жилийн турш ашиглалт, гүйлгээ муутай хэвээр байна. Энэ бүхэн бол коронавирусын хор уршгийг дагалдан БНХАУ болон бусад тэргүүлэх орнуудын эдийн засгийн байдал ихээхэн төвөгтэй болоод байгаатай холбогдож байна. Дэлхий дахины олон улс орнуудад эдийн засгийн өсөлт саарч олон үйлдвэрлэл зогсонги байдалд орж эдийн засгийн төлөв байдал муудаж байна.

Хоёр. Авч буй арга хэмжээ

Одоогийн байдлаар дэлхийн эдийн засаг 1 нэгж хувиар буурах төлөвийг гаргаад байгаа боловч цаашид үүнээс ч илүү буурах байдал гарч магадгүй. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 6 хувиас доошлуулж, 5 хувиар төлөвлөж байна. Хятад улс дэлхийд хамгийн том нөлөө бүхий орны хувьд эдийн засгаа аврахад онцгой ач холбогдол өгч ажиллаж байгааг бид сонсож байгаа. Энэ нь ч Монголд эерэг нөлөө үзүүлнэ.

Дэлхийн томоохон хөрөнгийн биржийн индексүүд сүүлийн саруудад 20 гаруй хувиар унаад байна. Эдийн засгийн уналтыг хязгаарлах, ажлын байрны хомсдолыг зогсоох, хөнгөвчлөх, өрх гэр, аж ахуйн нэгж, төрийн санхүүд учирч буй дарамтыг хөнгөвчлөх үүднээс улс орнууд өөрсдийн онцлогт тохирсон арга хэмжээ авч байна. Тухайлбал, Европын холбоо, Япон зэрэг үнийн өсөлтгүй болж харин буурах чиглэлд орж, зээлийн хүү нь хасах болсон орнууд зах зээлд нийлүүлэх мөнгөний хэмжээг тодорхой хөтөлбөр, бодлоготойгоор нэмэгдүүлж байна. Зээлийн хүүг бууруулах нөөцтэй АНУ, Англи, БНХАУ зэрэг улс орнууд зээлийн хүүг бууруулах, зах зээлд мөнгө нийлүүлэх явдлыг хослуулан хэрэглэж байна. Жишээ нь хөрш БНХАУ банкуудын заавал байлгах нөөцийг 0.5-1 нэгж пунктээр буулгасны зэрэгцээ зах зээлд олон зуун тэрбум юанийг нийлүүлсээр байна. Гадны зарим улсуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээллийг хавсаргав. (Хавсралт No1)

Коронавирустай тэмцэх талаар мэргэжлийн байгууллагууд, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээг энэхүү мэдээлэлд авч үзээгүй бөгөөд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бэлэн байлгах, эдийн засгийн хүндрэлийг даван туулах зарим санаа, мэдээллийг хүргэхийг оролдож буй болно.

Манай улсын хувьд мөнгө, төсөв, татварын бодлоготой холбогдсон зарим арга хэмжээг Засгийн газар, Монголбанкнаас авч эхлээд байна.

1. Коронавирустай холбоотойгоор Засгийн газраас үнийн хөөрөгдөл, хомсдол үүсэхээс сэргийлэх, ААН, бизнес эрхлэгчдээ дэмжих чиглэлээрүе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Импортын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх зорилгоор ОХУ-аас болон тус улсаар дамжуулан импортолж буй цагаан будаа, улаан буудай, өндөг, элсэн чихэр, ургамлын тосны гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 2 хүртэл сараар хойшлуулсан. (Энэ оны 4 дүгээр сард хууль батлуулахаар төлөвлөж байгаа).
- Коронавирусээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн хүний, техникийн, орны, эм, тарианы нөөц бүрдүүлэх зэрэгт Улсын төсвөөс ихээхэн хөрөнгө мөнгийг зарцуулж, зохих үр дүнд хүрч байгааг нарийчлан авч үзэх нь мэргэжлийн байгууллагын ажил болно гэж үзэж дэлгэрэнгүй тусгасангүй.

2. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн өртгийг бууруулах, санхүүгийн зуучлалыг дэмжих зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувь болгох, төгрөгийн заавал

байлгах нөөцийн хувь хэмжээг 8.5 хувь болгож 2 нэгж хувиар бууруулах, бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1,-1 хувь болгон өөрчлөх шийдвэр гаргасан. Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулснаар банкуудын чөлөөт эх үүсвэр 330 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжирч, уг эх үүсвэрийг зээлд зарцуулах боломжтой болж байна.

3. Татвар төлөгчдийн буюу төсвийн эх үүсвэрээс бүрдүүлдэг Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сантай шууд гэрээ байгуулсан, хэвийн зээлдэгчдийн зээлийн гэрээний дагуу 2020 оны гуравдугаар сарын 01-ний өдрөөс зургаадугаар сарын 30-ны хооронд төлвөл зохих зээлийн үндсэн төлбөрийг түр хугацаагаар хойшлуулж, зээлдэгчийн хүсэлтээр зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах, дээрх хугацаанд алданги тооцохгүй байх зэрэг арга хэмжээг авч, жижиг, дунд бизнес эрхлэгчдээ дэмжихээр Засгийн газраас шийдсэн байна. Уг хөнгөлөлтөнд аливаа хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа, шүүхийн шийдвэрээр маргаан үүссэн, төрийн өндөр албан тушаалтнуудтай хамаарал бүхий этгээдүүдийн авсан зээлийн үндсэн төлбөр, алданги хамаарахгүй болно.

Гурав. Санал дүгнэлт, цаашид авах арга хэмжээ

Дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

Банкны болон төсвийн зээлийн асуудалд ялгавартай хандах учиртай. Тухайлбал үнэтэй эх үүсвэр (иргэд, байгууллагын хадгаламж, гадаад зээллэг зэрэг)- ээс олгосон зээлийн үндсэн төлбөр, хүүг бууруулах асуудлыг УИХ, Засгийн газраас захиргааны журмаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд зөвхөн зээлдэгч, зээлдүүлэгч хоёрын харилцан ойлголцлын асуудал билээ. Харин татвар төлөгчдийн буюу төсвийн эх үүсвэртэй зээлийн асуудлыг Засгийн газраас нааштайгаар шийдэж болдгийн нэг жишээ нь дээр дурдсан ЖДҮ-ийн сангийн зээлдэгчдэд төрөөс үзүүлсэн хөнгөлөлт билээ. Жилийн инфляци өмнөх оны мөн үеэс 6.4 хувь, гадаад валютын ам.доллар төгрөгтэй харьцах ханш өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсчээ. Монголбанкны инфляцийг дунд хугацаанд 6 хувьд тогтворжуулах мөнгөний бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд төсвийн болон Засгийн газрын цалин тэтгэвэр, үнийн бодлого чиглэгдэх учиртай биз ээ. Эдгээр тоо баримт арилжааны банкуудын зээл, хадгаламжийн хүүгийн түвшинд хүндэтгэлтэй хандахыг сануулж байна.

Сүүлийн үед Дэлхий дахины санхүү, эдийн засгийн байдал хяналтаас гарч 1998, 2008-2009 оны санхүүгийн хямралаас хүнд тусаж болохыг анхааралдаа авч зарим улс орнууд тодорхой арга хэмжээ авч эхлээд байна. Тухайлбал, АНУ-ын Нөөцийн сан /Төвбанк/ 1 их наяд ам.доллар, ХБНГУ 500 орчим тэрбум ам.доллартай тэнцэх зээлийн эх үүсвэрийг зах зээлд нийлүүлэхээ амлаж хэрэгжүүлж эхлээд байна.

Япон, Герман, Өмнөд Солонгос зэрэг экспортын баримжаатай, валютын нөөц ихтэй эдийн засаг бүхий орнууд үндэсний эдийн засаг, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дэлхий дахинд үүсээд байгаа хоосон орон зайг нөхөх дэс дараатай бодлого явуулж эхлээд байна. Үр дүн нь ч гарах төлөвтэй байна. Өмнөд Солонгос Улсын экспорт 2020 эхний 2 сарын дотор 20 гаруй хувиар өссөн мэдээлэл байна.

Монгол Улсын хувьд хуримтлал /хадгаламж/ багатай, инфляци өндөр, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш унах /Монголбанкнаас арилжааны банкуудад тодорхой зорилгогүй эх үүсвэр нэмэгдүүлвэл үүгээр валют худалдан авч эрэлт үүсгэвэл ханш унах эрсдэлтэй/, Монгол Улс өөрөө импортод голлосон эрэлттэй учраас зээлийн хүүг огцом бууруулах, зах зээлд их хэмжээний сул хөрөнгийг гаргах боломжгүй юм. Нөгөө талаас төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрлэлээ дэмждэг олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлж чадахгүй байна. Монгол Улсын 2020 оны төсвөөс үзэхэд 5 их наяд төгрөгийг бараа, ажил үйлчилгээ худалдан авахад зориулан зарцуулахаар байна. Үүнээс гадна төрийн өмч бүхий цахилгаан станц, уурхай, эрчим хүчний зэрэг олон аж ахуйн нэгжүүд их хэмжээний худалдан авалт хийдэг. Монгол Улсын Засгийн газраас тендер шалгаруулахдаа дотоодын давуу эрхийг зайлшгүй тооцож байхыг төсвийн байгууллагууд, захиалагчдад үүрэг болгосон ч энэхүү давуу эрхийг тооцоход адилтгах импортын барааны үнийн зэрэгцүүлэлт хийх, барааны дотоодод үйлдвэрлэсэн гэсэн баталгаа, гарал үүслийн баталгаа зэргийг шаарддаг учраас тендерийн хорооны гишүүд төвөгшөөж дотоодын үйлдвэрлэлийг тэр бүр шалгаруулаад байдаггүй. Нөгөө талаар тендер тойрсон хээл хахууль дотоодын үйлдвэрлэлд биш импортын сүлжээ (гадаадын нийлүүлэгчтэй үгсэн хуйвалдаж)-нд тулгуурладаг. Эдгээр асуудлыг боловсронгуй болгох хүртэл дотоодын үйлдвэрлэгчдээс шаарддаг олон шаардлагыг хүчингүй болгож, дотоодын үйлдвэрлэлийг заавал ашиглана гэдэг үүргийг бүх захиалагчид, барилга гүйцэтгэгчдэд өгөх нь зүйтэй байна.

Эдийн засгийн эгзэгтэй өнөө үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, санхүүгийн салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулахгүй байх явдал юм. Коронавирусийн хор уршгийг арилгахад Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 10 гаруй тэрбум төгрөг зарцуулаад байгаа мэдээ байна. Засгийн газрын нөөц хөрөнгөнд 2020 онд 25.0 тэрбум төгрөг төлөвлөсөн байгаа. Гэтэл энэ тахлаас гадна мал сүргийн хаваржилтыг даван туулах, хаврын тариалалт, шар усны үер, ой хээрийн гал түймэр гэх мэт олон тооцож болохгүй арга хэмжээ, эрсдэл гарна. Энэ бүхэн төсөвт сөрөг нөлөөлөл үзүүлэх болно. Бусад зардалд хэмнэлт гаргаж, энэ чиглэлээр зарцуулах боломжийг УИХ-аас Засгийн газарт олгох хэрэгтэй болно.

Нөгөө нэг онцгой анхаарах зүйл бол импортыг ялангуяа стратегийн зориулалттай хүнс, бензин, шатахуун, үйлдвэрлэлийн түүхий эдээс бусад импортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч болохгүй. Учир нь экспортын орлого унаж, энэ онд хийгдэх томоохон хэмжээний гадаад өрийн төлбөрүүд хийгдэх гэж буй үед гадаад валютын нөөц хүрэлцэхгүй бөгөөд төгрөгийн ханшийг унагах, төлбөрийн тэнцлийг улам хүндрүүлж, төсвийн орлогын баазыг хумих хор уршигтай. Харин дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихийг урьтал болгох нь хүндрэлээс гарах хамгийн зөв зам байх болно. Гэхдээ иргэд нэгэнт хорио цээрийн дэглэмд байгаа үед ямар ч идэвхжүүлэх арга хэмжээ үр дүнгүй юм. Зөвхөн Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд, зээлийн үлдэгдлээс үзэхэд импорт орлосон, экспортын чиглэлтэй нэлээдгүй хүчин чадал бий болжээ. Тухайлбал, барилгын материал, хийц хэсгийн болон хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглахад зориулсан үйл ажиллагааг хөрөнгө, мөнгө, зээл, хүү,

татварын бодлогоор дэмжих шаардлагатай болжээ. Тэд ихээхэн зээлтэй болохыг хэвлэл мэдээллээр ихээхэн гарсан бөгөөд гагцхүү гарцаа хамтраад шийдэх нь зохилтой.

Монгол Улс мал аж ахуйн түүхий эдийн 20 хүрэхгүй хувийг өөрсдөө бэлтгэж дотоод болон гадаад зах зээлд нийлүүлж байгаа юм. Энэ хувь хэмжээг цаашид нэмэгдүүлэх, Монгол Улсын хүн амын 1/3 болсон малчид, тэдгээрээс хамаарал бүхий иргэдийн орлогыг багасгахгүй байлгах явдал тулгамдсан зорилтын нэг юм. Үйлдвэр аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө дутмаг, хүчин чадлаа бүрэн ашиглах хэмжээнд улирлын чанартай түүхий эдээ өндөр хүүтэй арилжааны зээлээр хангах нь тэдэнд туйлын эрсдэлтэй хэвээр байна. Нөгөө талаар европ, америк, азийн ихэнх зах зээл удаан хугацаанд хаагдсан үед үйлдвэрлэл нэмэгдээд ч борлуулалт хязгаарлагдмал болно. Тухайлбал, ноолууран бүтээгдэхүүний томоохон зах зээлүүд түр хаагдсан байгаа. Тиймээс үйлдвэрлэлийн төдийлөн их биш зохистой түвшинд хадгалах, зээлийн эргэн төлөлт нь санхүүгийн эргэлтийн хөрөнгийн хүндрэлийг нэмэх тул зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах илүү зохистой дэмжлэг байх болно. Олон сараар ашиглах өндөр хүүтэй зээлтэй байх нь манайханд эрсдэлтэй учраас Хятадын худалдаачид Монгол Улсын түүхий эдийн дийлэнхийг цуглуулж, хагас дутуу боловсруулан гаргаж байна. Энэ жилийн хувьд энэ чиглэлийн бизнес эхлэх эсэх нь мөн тодорхойгүй байна. Үүнийг зохион байгуулалтад, бэлэн бус тооцооны хэлбэрээр, албан ёсны үнэнч шударга гэрээний зарчимд шилжүүлэх хэрэгтэй байна. Мөн манай үүргийн худалдаачид хил даван өөрийн биеэр бараа зөөвөрлөх боломжгүй бөгөөд үүнийг цаашид бүрэн зогсоож, албан ёсны гэрээ контрактын худалдаанд шилжинэ гэсэн хүлээлтийг бий болгох нь эрүүл мэндийн, эдийн засгийн зэрэг олон ач холбогдолтой болно. Мөн хүнсний аюулгүй байдлын асуудал юм.

Дараах санал оруулж байна. Үүнд:

Үүсээд буй хүндрэлийг боломж гэдэг талаас нь харж, Дэлхийн хамгийн том, тогтвортой зах зээлүүдтэй хаяа нийлэн амьдарч буй орны хувьд Монгол Улс байдлыг нааштайгаар эргүүлэхийг оролдох нь зүйтэй. Төрөөс гаргаж буй дипломатын болон гадаад худалдааны бодлогын хүчин чармайлтыг улам чамбайруулж, үр дүнд хүргэхийг хүсэж байна. Иймээс төсвийн тодотгол хийх зэрэг эрх зүйн хийгээд техникийн шинжтэй арга хэмжээг урьдал болгохоос өмнө төсвийн орлогын тасалдлыг нөхөх, бүх шатны төсвийг дээд зэргийн арвилан хэмнэлтийн зарчимд шилжүүлэх чиглэлээр ажиллахад шаардлагатай эрх зүйн үндсийг бүрдүүлж, Засгийн газрыг шуурхай ажиллах боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Өдгөө орлого, зарлагыг ямар хэмжээгээр буурахыг нэр төрлөөр нь тооцоход тодорхой бус зүйлс байгаагийн хамт цаг үеийн зайлшгүй зардлыг нөөцөөсөө гаргаж байгаа тул одоогоор төсвийн тодотгол хийхийг гол болгохгүйгээр дараах арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Ø Төсвийн алдагдлыг УИХ-аас баталсан хэмжээнд багтаан, төсөв, санхүүд эрсдэл учруулахгүйгээр төсвийн орлого, зарлагыг зохицуулалт хийж ажиллахыг Засгийн газарт зөвшөөрөх. Энэ хүрээнд доорх ажлыг зохион байгуулах:

Ø Засгийн газар, төр, захиргааны бүх байгууллага, хувийн хэвшил бүхэлдээ экспортын зарим бүтээгдэхүүний тасалдлыг нөхөж, төлөвлөсөн орлогын хэмжээнд хүргэх арга хэмжээг авч ажиллах, гадаад, дотоод талаас экспортод аливаа хязгаарлалт, саад хориг үүсэх нөхцлийг бүрэн хаах.

Ø Ажлын байрыг хадгалах, дотоодын нөөц бололцоо ялангуяа, өвлийн улирал дуусаж, хавар зун, намрын ажлын бэлтгэлийн байдалд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авах.

Ø Малаас гарах үндсэн түүхий эд болох 400 гаруй мянган тонн мах, 30 гаруй мянган тонн хонины ноос, 10-аад мянган тонн ямааны ноолуур, 15-аас доошгүй сая ширхэг арьс, ширний нөөц байна. Эдгээрийг цуглуулж эргэлтэд оруулна гэвэл ойролцоогоор 3 их наяд гаруй төгрөг буюу 1.1 тэрбум ам.доллар гарах юм. Эдгээрийг бэлтгэж, боловсруулж, экспортод гаргахад зориулж 500.0 орчим тэрбум төгрөгийн зээлд 5 хувь нэгж хүүний хөнгөлөлтийг улсаас олгохыг санал болгож байна. Үүнд 25.0 орчим тэрбум төгрөг шаардагдана. Арилжааны банкууд Монгол Улсын Хөгжлийн банкттай хамтран 13 хувийн хүү (бодлогын хүү 10 хувь, банкны зардлаа нөхөх хүү 3 хувь)- тэйгээр дурдсан зориулалтаар экспортлогч аж ахуйн нэгжид олгож, хэрэгжилтийг хангаж чадвал, үйлдвэрүүдэд зээлийн хүүний зөрүү 5 хувийг төсвөөс Хөгжлийн банкаар дамжуулан олгох хувилбар байж болох юм гэж үзэж байна. Үүнд шаардагдах хөрөнгийг төсвийн зардалд хэмнэлт гаргах замаар шийдвэрлэхийг УИХ-аас Засгийн газарт олгож буй бүрэн эрх гэж үзэж болно. Төсвийн орлого маш өндөр шахуу төлөвлөсөн гэтэл дэлхийн зах зээл дээр манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ буурч байна. Төсвийн орлогын алдагдлыг нөхөх хүчин чармайлт бэрхшээлтэй тулгарч болзошгүй тул төсвийн нийт зардлыг 500 тэрбумаас нэг их наяд төгрөгөөс доошгүйгээр бууруулах тооцоог олон хувилбараар хийж, нөхцөл байдалд нийцүүлэн уян хатан ажиллах шаардлага үүсэж байгааг хүлээн зөвшөөрөх.

Ø Төсвийн зардлын хэмнэлтээс 50-иас доошгүй тэрбум төгрөгийг гаргаж, ЖДҮ- ийн санд хуваарилах.

Ø Дотоодын бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид, хэрэглэгчид, худалдан борлуулагчдыг хамруулсан, харилцан уялдуулсан сүлжээнд оролцогчдыг санхүүжүүлэх нэгдсэн механизмыг бий болгож гадаад, дотоодын албан ёсны эх үүсвэр татах талаар хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх. Ялангуяа цахилгаан станц, төмөр замын төслүүдийг гадаадын албан ёсны эх үүсвэрийн санхүүжилтийн оролцоотойгоор өөрсдийн хүчээр гүйцэтгэх.

Ø Татварын 2019 оны шинэчлэлээр аж ахуйн нэгжүүдэд олгох болсон татварын болон бизнесийн олон төрлийн хөнгөлөлтийг (50 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжид орлогын 1 хувиар, 50-300 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 10 хувиар татвар төлөх, мөн 500-аас дээш км-ийн алслалтай аж ахуйн нэгжийг 50 хувь, 1000 дээш км-ийн алслалтай аж ахуйн нэгжийн татварын 90 хувь хөнгөлөлт) эдлүүлэх

ажлыг хөнгөвчилж аж ахуй эрхлэгчдийн мэдлэг мэдээлэлд хүргэх ажлыг далайцтай зохион байгуулах.

Ø Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт” болон “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-д арьс, шир, түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хамруулах хугацааг хойшлуулах санал оруулж байна. Сүүлийн жил гаруй хугацаанд мал аж ахуйн арьс, шир үнэ цэнэгүй болсон бөгөөд малчид, худалдаачид арьс, ширийг бэлтгэхэд туйлын хойрго хандаж зарим тохиолдолд их хэмжээний арьс хог хаягдал болж байна. Нөгөө талаар энэхүү тогтоолд дурдсан чанарын тохируулгыг бүх арьсанд хийх хүчин чадал одоогоор бүрдээгүй байна. Арьс, ширний цөөхөн үйлдвэр байгаа ч тэдэнд эргэлтийн хөрөнгө байхгүйгээс арьс ширийг худалдан авч чадахгүй байна. Ийм учраас дээрх хүчин чадал бий болгох, малчдын орлогыг нэмэгдүүлэх зэрэг шалтгаанаар уг тогтоолын нэгдүгээр хавсралтын 41 буюу “Арьс, ширэн түүхий эд, боловсруулсан арьс шир, үслэг арьс болон тэдгээрээр хийсэн эдлэл; суран эдлэл болон тоног хэрэгсэл; аяны хэрэгсэл, эмэгтэй хүний цүнх болон түүнтэй төстэй уут сав; мал амьтны өлөн гэдсээр хийсэн зүйлс (төөлүүр 6 хорхойн утаснаас бусад)” гэсэн хэсгийн хэрэгжилтийг 2023 оноос эхлэхээр өөрчлөлт оруулах.

Ø Төрийн худалдан авалтаар дотоодын үйлдвэрлэлийг шууд дэмжиж, аливаа саад тотгорыг бүрэн арилгахыг санал болгож байна. Үүсээд байгаа нөхцөл байдлыг даван туулахад дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжихэд чиглүүлэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн зарим заалтуудыг түр түдгэлзүүлэх, цаашид боловсронгуй болгох шаардлага харагдаж байна. Тухайлбал дотоодын үйлдвэрлэгчдэд давуу эрхийг элдэв тендер, шалгуур үзүүлэлтгүйгээр шууд олгож гэрээ хийдэг бүрэн эрхийг төсвийн болон төрийн өмчит бүх аж ахуйн нэгжид 2020 оны 5 дугаар сарын 01-нээс эхлэн туршилтын журмаар 2 жилийн хугацаанд олгож, тендерийн хуульд заасан холбогдох заалтуудын үйлчлэлийг түр зогсоох. Энэ хугацаанд тендерийн шалгаруулалтад авч үздэг үнийн харьцуулсан үнэлгээ, барааны гарал үүсэл, өртгийн талаархи мэдээлэл, нотлох баримт бичиг зэргийг хялбаршуулсан байдлаар тогтоох, давуу эрх олгох аргачлал, зааврыг шинэчлэх (төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална) хэрэгтэй болно. Мөн дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг (Засгийн газар батална) нөхцөл байдалд тохируулан өөрчлөх шаардлагатай байна. Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг тендер зарлахгүйгээр шууд худалдан авах боломжийг бий болгосон журмыг Засгийн газраас тогтоох, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Доорх яаралтай арга хэмжээг авах. Үүнд:

1. 2020 онд шинээр эхлэхээр төлөвлөсөн үйлдвэрлэлийн бус хөрөнгө оруулалтыг (эхлээгүй, зураг төсөвгүй, тендерээ дүгнээгүй, тоног төхөөрөмж авах гэх мэт) зогсоож, дараа онд шилжүүлэх;

2. Коронавирустэй холбогдсон зардал өсөх нь тодорхой учраас захиргааны зардлыг бууруулах арга хэмжээ авах:
 - Байрны засвар, гэрэл цахилгаан, тохижилт, сандал ширээ, бичиг цаас зэрэг тэргүүн ээлжийн бус зардлын төсвийг 30 хувиар бууруулах,
 - Энэ оныг дуустал элдэв хурал, зөвлөгөөн хийх, ой, баяр тэмдэглэх (Улсын баяраас бусад) сургалт, семинар зохиохыг хориглох,
 - Барих-шилжүүлэх концессийн нөхцлөөр 2020-2021 онд дуусах барилга байгууламжийн эргэн төлөлтөд төлөвлөсөн хөрөнгийг 2021-2022 он болгон хойшлуулах.
3. Энэ оны 9 дүгээр сарын 01 хүртэл аливаа байгууллагын данснаас данс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр элдэв суутгал, татан авалт, дайчлалт хийхгүй, данс хаахгүй байх;
4. Коронавирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн салбарын чадавхийг бэхжүүлэх, нэн шаардлагатай бус төсвийн зардлыг эрүүл мэндийн салбарт чиглүүлэх, зардлыг оновчтой хуваарилах талаар арга хэмжээ авах;
5. Эмзэг бүлгийн иргэдийг коронавирусээс хамгаалах арга хэмжээнд зориулан хөрөнгө гаргахыг нийт засаг захиргааны нэгжүүдэд үүрэг болгох;
6. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, санхүүгийн салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулахгүй байх;
7. Зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, бүтцийн өөрчлөлт хийх, зээлийн тасалдал үүсэхээс сэргийлж зарим зохицуулалтын арга хэмжээг түдгэлзүүлэх боломжийг судалж, шийдвэрлэх;
8. Улс хоорондын үүргийн худалдааг тодорхой хугацаагаар зогсоож, гэрээт худалдаанд бүрэн шилжих.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

--oOo--

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ

1. НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын 2021 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй танилцаж судалгаа хийв.

Цар тахлын нөлөөгөөр буй болсон төсвийн алдагдлыг ирэх онд бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах, халамжаас ажлын байрыг урьтал болгож, иргэдийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар төсөв, сангийн бодлогыг хэрэгжүүлэхээр байгааг дэмжиж байна.

Малын тоо, бэлчээр, байгаль орчны доройтол, малчдын хэрэгцээ зэрэг нь малыг дээд хэмжээнд хүртэл тавааржуулах ажлыг бүх талаар, түүний дотор төсөв, мөнгөний бодлогоор дэмжих шаардлага үүссэн байна.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу УИХ төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болох бөгөөд Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж болохгүй гэж заасан байна. Үүний дагуу Засгийн газар төсвийн алдагдлын хэмжээ болон түүнийг хэрхэн нөхөх асуудлыг УИХ-ын өмнө бүрэн хариуцахаар болсон байна.

2021 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 11.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 27.9 хувь, нийт зарлагыг 13.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 33.0 хувь, төсвийн алдагдлыг 2.15 их наяд төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувь байхаар төлөвлөжээ. Эдийн засаг өсөлттэй, төгрөгийн ханш тогтвортой байхад төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй байх хуулийн заалттай. Иймээс Засгийн газар төсвийн менежментийг 2021 онд өмнөх 2 жилийн нэгэн адил суурь хуульд нийцүүлэн явуулахыг эрхэмлэнэ гэж найдаж байна. Ийм гадаад, дотоод нөхцөл боломж ирэх онд үүснэ хэмээн төсөөлж байна.


Сүүлийн 7 жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл (*хавсралт хүснэгт №6*)-ээс үзэхэд 3 жилд нь алдагдлыг ДНБ-ий 2 хувийн дотор барьж чадаж байсан бол бусад жилүүдэд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн суурь зарчмыг мөрдөхгүйгээр хуульд өөрчлөлт оруулах замаар шийдэж байжээ. Чингэхдээ УИХ-ын сонгуулийн жилд төсвийн норм, эрх зүй илүүтэй зөрчөгдөхөд хүрч, төсвийн алдагдал ихэссэн байна.

Монгол Улс сүүлийн жилүүдэд төсвийн сахилга батыг сайжруулан төсвийн алдагдал, өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн мөчлөг сөрсөн мөнгө, төсвийн бодлого явуулж, татварын болон төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлснээр мөнгө, санхүүгийн тодорхой нөөцийг 2020 оны эхэнд бүрдүүлсэн юм. Энэ нь 2020 оны эхнээс дэлхий дахинаа дэгдсэн Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг олгожээ. Гэхдээ цаашдаа төсөв, хөрөнгийн дутагдалд орох эрсдлээс сэргийлэх нь чухал болно.

Бас нэг тулгамдсан асуудал өр байна. Өрийн хэмжээ их байгаагийн дээр ойрын жилүүдэд бондуудын эргэн төлөлт хийгдэх тул зээлийн асуудалд онцгой анхаарал тавьж, төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах нь нэн чухал байна.

Энэ хүрээнд Засгийн газар Номад бондыг бага хүүтэйгээр олон улсын зах зээлд борлуулж, өндөр хүүтэй Мазаалай бондын өрийг барагдуулах боломж үүсгэж, хүүний зөрүүгээр төсвийн ачааллыг 26.5 сая ам.доллар буюу 70 гаруй тэрбум төгрөгөөр бууруулсан нь чухал ач холбогдолтой болжээ.

Ер нь Монголд орсон нийт гадаад санхүүжилтийн үлдэгдэл сүүлийн 10 жилд хэрхэн өсөж ирснийг өр үүсгэх ба үл үүсгэх гэж ангилан доор үзүүллээ.



Дээрх графикаас үзэхэд зээлийн үлдэгдэл 30.8, зээлийн санхүүжилтгүй гадаадын хөрөнгө оруулалтынх 12.5 тэрбум ам.доллар байна. Нийт зээл дотор шууд хөрөнгө оруулалтад тооцогддог гадаадын компани хоорондын зээлийг оролцуулбал гадаадын компаниудын нийт хөрөнгө оруулалт өнгөрсөн оны эцсээр 22.55 тэрбум ам.доллар болжээ. Сүүлийн жилүүдэд уул уурхайгаас өөр салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт бараг хийгдэхгүй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, динамикийг хавсралт хүснэгт №7-д үзүүллээ. Энэхүү хавсралт хүснэгтээс гадаадын шууд хөрөнгө оруулалт эдийн засгийн аль салбарт түлхүү орсныг судалж, бодлого, стратегиа боловсруулах боломжтой. Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 77.6 хувь буюу 17.1 тэрбум ам.доллар нь уул уурхайн салбарт ногдож байна. Өрийг төлөх эх үүсвэрийг бүрдүүлэх нь чухал юм.

Зээлийн өрийн үлдэгдлийг Загийн газар, банк, аж ахуйн нэгж гэсэн үндсэн хэрэглэгчдээр гаргаж доор үзүүллээ.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР
/2020 оны эхний хагас жилийн байдлаар/ Сая ам.доллар

Үзүүлэлт	Засгийн газар	Монголбанк	Банк	Бусад ААН	Нийт
Монгол Улсын нийт гадаад өр	7.891	2.084	1.703	19.136	30.814

Засгийн газар, Монголбанкны өр зээлийн үйлчилгээний төлбөр төсөвт шууд нөлөөлдөг бол аж ахуйн нэгж, банкны өр зээл нь тэдний зардлыг нэмэгдүүлж, улмаар татвар ногдуулах орлогыг бууруулж, төлбөрийн тэнцлийг хүндрүүлж байна. Төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2020 онд 1.99 тэрбум ам.доллар болсныг хавсралт хүснэгт №5-аас үзнэ үү. Иймээс дунд, урт хугацаанд валютын нөөц нэмэгдүүлэх, валютын хэмнэлт үүсгэх ач холбогдолтой, төлбөрийн болон төсвийн тэнцлийг сайжруулахад чухал нөлөөтэй төсөл, хөтөлбөрүүдийг төрийн мөнгө зээл, төсвийн бодлогоор дэмжиж, өр төлөх боломж бүрдүүлэх нь стратегийн зорилт болно.

Өр нь гадаад зээлийн процесс, үйл ажиллагаа, бодлогод зарчмын өөрчлөлт хийж, цаашдаа аливаа арилжааны шинжтэй зээл, бондыг Засгийн газар санаачлан гарын үсэг зурж авдаг байдлыг зогсоож, төлөгдөх эх үүсвэр нь тодорхойгүй, төсөвт дарамт үзүүлэх зээлээс татгалзахаас өөр аргагүй болж байна. Зээл ашиглаж, хэрэглэдэг байгууллагуудын урдуур орж Засгийн газар буюу сангийн яам зээл авах явдлыг хязгаарламаар байна. Эргээд төлөгдөх эх үүсвэр бүрдүүлдэг үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан тэдэнд хариуцлагыг нь үүрүүлэн гадаадаас зээл авах журам, зарчим тогтоох шаардлага үүсэж байна. Төсөв алдагдалтай, дотоод хуримтлал багатай болохоор төсвийн аливаа нэмэгдэл зардлыг наад зах нь 10-аас доошгүй (гадаад зээлийн суурь хүү дээр нь төгрөгийн ханшийн жил бүрийн уналтыг тооцвол) хувийн зээл авч, санхүүжүүлж буй хэрэг билээ.

Сүүлийн жилүүдийн нэгдсэн төсвийн төсвийн тэнцэл, өр зээлийн байдлыг дараах хүснэгт №1-д үзүүлээ.

Хүснэгт №1: Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020		2021	2022	2023
	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Бат.	Тод.	Төсөл	Төс.	Төс.
ДНБ-ий бодит өсөлт (хувиар)	1.2	5.3	7.3	7.0	6.0	-1.0	7.2	4.4	6.5
Хэрэглээний үнийн индекс (хувиар)	0.1	7.7	8.6	8.0	8.0	3.8	7.0	6.0	6.0
Тэнцвэржүүлсэн орлого	5,835.0	7,274.9	9,345.1	10,095.5	11,797.8	9,730.9	11,797.8	11,421	12,003
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>24.4</i>	<i>26.8</i>	<i>29.1</i>	<i>29.6</i>	<i>29.0</i>	<i>25.2</i>	<i>27.9</i>	<i>25.0</i>	<i>24.0</i>
Нийт зардал ба цэвэр зээл	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,872.6	14,577.5	13,951.6	13,069	13,404
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>39.8</i>	<i>33.2</i>	<i>29.0</i>	<i>31.6</i>	<i>34.1</i>	<i>37.7</i>	<i>33.0</i>	<i>28.6</i>	<i>26.8</i>
Төсвийн тэнцэл (тэнцвэржүүлсэн орлогоор)	-3,660.3	-1,742.5	27.9	-756.2	-2,074.7	-4,846.6	-2,153.7	-1,648	-1,401
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>-15.3</i>	<i>-6.4</i>	<i>0.1</i>	<i>-2.0</i>	<i>-5.1</i>	<i>-12.5</i>	<i>-5.1</i>	<i>-3.6</i>	<i>-2.8</i>
Хөрөнгийн зардал	2,360.2	1,658.1	1,680.4	3,016.6	3,679	3,408.0	3,498.5	3,204	3,034
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>9.9</i>	<i>6.1</i>	<i>5.2</i>	<i>8.2</i>	<i>9.0</i>	<i>8.8</i>	<i>8.3</i>	<i>7.0</i>	<i>6.1</i>
Зээлийн хүүний төлбөр	986.1	1,156.5	1,046.4	860.9	960	972.6	1137.5		
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>4.1</i>	<i>4.3</i>	<i>3.3</i>	<i>2.3</i>	<i>2.4</i>	<i>2.5</i>	<i>2.7</i>		
Өр, өнөөгийн үнэ цэнээр			18,956	20,526	22,089		26,141	25,863	26,620
<i>ДНБ-д эзлэх хувь</i>			<i>58.9</i>	<i>55.6</i>	<i>54.3</i>		<i>61.9</i>	<i>56.5</i>	<i>53.2</i>
Нэрлэсэн ДНБ	23,886.4	27,167.0	32,165.9	36,898.6	40,683.1	38,688.3	42,230.1	45,775	50,038

Эх сурвалж: Сангийн яам

ДНБ-д эзлэх төсвийн тэнцлийн хувь 2021 онд (2020 оны тодотголоос) 7.4 нэгж хувиар, харин 2022 онд 1.5 нэгж хувиар, 2023 онд 0.8 нэгж хувиар сайжрах төлөвтэй байна.

2. ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТӨСВИЙН ТЭНЦЛИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

1. Төсвийн орлого

Ирэх онд эдийн засгийн идэвхжил эргэн сэргэж төсвийн орлого 2020 оны батлагдсан орлогын түвшинд хүрэхээр байна. 2021 онд татварын болон татварын бус орлогыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн хэдий ч 2020 оны батлагдсан дүнгээс бага байхаар төсөлд тусгажээ. Харин орлогын бусад бүрэлдэхүүн хэсгийг 2020 оны батлагдсан дүнгээс нэмэгдүүлэхээр төсөөлж байгаа бөгөөд үүний дотор АМНАТ-ийн орлогыг 2020 оны батлагдсан дүнгээс 25.0 хувь, тодотголоос 30.6 хувиар өсгөхөөр төлөвлөжээ. Төсвийн орлогыг бүрэн биелүүлэх ажлыг оны эхнээс шуурхай зохион байгуулаж зэс, нүүрсний экспорт, газрын тосны импорт зэрэгт аливаа тасалдал гаргахгүй байх нь чухал.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас хэрэгжүүлж буй татварын шинэчлэлийн хүрээ улс орнуудыг мэдээлэл харилцан солилцох, дижитал эдийн засгийг татваржуулахад чиглэж байгаа үед Монгол Улс татварын шинэчлэлийн хүрээнд татвар ногдуулах, хураах, хянах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулахыг зорьж олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаа болно. Энэ бүхэн төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй ажил болох ажээ.

Төсвийн тооцоонд тусгасан экспортын гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үнийн таамаглал нь 2021 онд өсөлттэй байхаар олон улсын байгууллагуудаас гаргасан төсөөлөлд үндэслэжээ. Монгол Улсад хамааралтай таваарын бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнийн голлох зах зээлийн үнийн динамикуыг графикаар гарган харуулав. (Хавсралт график №1, №2, №3, №4-ийг үзнэ үү)

Хүснэгт №2: Нэгдсэн төсвийн 2020, 2021 оны төсвийн орлогын үзүүлэлтүүд

Тэрбум төгрөг

Үзүүлэлт	ТТӨ-д эзлэх хувь 2021	Төсвийн орлогын харьцуулалт				ДНБ-д эзлэх хувь		
		2020	2021	Зөрүү, тэрбум төгрөг	Өсөлтийн хувь	2020	2021	Зөрүү
		Тодотгол	Төсөл			Тод.	Төсөл	
Нийт орлого ба тусламжийн дүн	100.0	10,729.3	13,134.0	2,404.7	22.4	27.7	31.1	+3.4
Тогтворжуулалтын сан	1.2	55.1	156.0	100.8	182.9	0.1	0.4	+0.3
Ирээдүйн өв сан	9.0	943.2	1,180.1	236.9	25.1	2.4	2.8	+0.4
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	89.8	9,730.9	11,797.8	2,066.9	21.2	25.2	27.9	+2.7
1 Татварын орлого	91.3	8,847.1	10,754.4	1,907.2	21.5	22.9	25.5	+2.6
1.1 Орлогын албан татвар	24.4	2,593.8	2,885.0	291.2	11.2	6.7	6.8	+0.1
1.1.1 ХХОАТ	8.5	857.4	1,002.6	145.2	16.9	2.2	2.4	+0.2
1.1.2 ААНОАТ	16.0	1,736.4	1,882.6	146.2	8.4	4.5	4.5	-
1.2 НДШ	16.9	1,520.2	1,996.7	476.5	31.3	3.9	4.7	+0.8
1.3 Хөрөнгийн албан татвар	1.5	152.2	175.7	23.0	15.1	0.4	0.4	-
1.4 НӨАТ	23.8	2,277.9	2,804.0	526.0	23.1	5.9	6.6	+0.7
1.5 Онцгой албан татвар	8.0	734.9	939.2	204.3	27.8	1.9	2.2	+0.3
1.6 Тусгай зориулал-тын орлого	0.2	15.9	20.0	4.1	25.8			
1.7 Гаалийн албан татвар	7.9	770.9	935.0	164.1	21.3	2.0	2.2	+0.2
1.8 Төлбөр, хураамж	8.5	780.7	998.7	218.0	27.9	2.0	2.4	+0.4
2 Татварын бус орлого	8.8	883.7	1,043.4	159.6	18.1	2.3	2.5	+0.2
2.1 Нийтлэг орлого	7.6	732.7	892.7	159.9	21.8	1.9	2.1	+0.3
2.2 Хөрөнгийн орлого	3.3	750.0	400.0	-350.0	-46.7	0	0	
2.3 Тусламжийн орлого	1.2	150.3	150.3	-	-	0.4	0.4	

Эх сурвалж: Сангийн яам (2020)

Судалгаанаас дүгнэхэд, татварын бааз, суурийг нэмэгдүүлэх, тухайлбал, НӨАТ-ын урамшууллын системээр дамжуулан НӨАТ-ыг мөн чанараар нь хэрэгжүүлж, далд эдийн засгийг ил болгож, мөн ААНОАТ-ын хөнгөлөлт үзүүлэх замаар бизнесийг дэмжиж, төсөвт төвлөрүүлэх ААН-ийн болон хувь хүний орлого, хөрөнгийн татварын орлогыг нэмэгдүүлэх боломжтой нь харагдлаа. Үүний зэрэгцээ Татварын албаны хөндлөнгийн мэдээллийн системийг ашиглан төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг өсгөж, татвараас зайлсхийх боломжийг хязгаарлаж болно.

Эдийн засаг, нийгэмд үзүүлж буй АМНАТ, НӨАТ, Онцгой албан татвар, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын нөлөөллийг нийгмийн бүлэг, жендэрээр ангилан тооцоолж татварын бодлого, зохицуулалтын үр нөлөөг үнэлдэг болох нь зүйтэй. Түүнчлэн “Монгол Улсын Үндсэн хууль”-д орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу орон нутгийн татварын болон орон нутгийн өмчийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь чухал болно.

Ногдуулахаар тооцож буй Малын хөлийн татварыг малчдын хуримтлалтай, даатгалтай болох сонирхолыг төрүүлэхэд зориулан ашиглах нь оновчтой байх болно.

2. Төсвийн зарлага

Монгол Улсын Нэгдсэн төсвийн нийт зардал 2021 онд 2020 оны тодотгосон дүнгээс 4.3 хувиар хумигдах бөгөөд үүний дийлэнх хувийг бараа, үйлчилгээний болон цалингийн зардал, цэвэр зээлийн зардал эзлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №3: Монгол Улсын Нэгдсэн төсвийн зарлага

Тэрбум төгрөг

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020		2021	Зөрүү
	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Бат.	Тод.	Төсөл	
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,872.6	14,577.5	13,951.6	-625.9
УРСГАЛ ЗАРЛАГА	6,613.8	7,043.2	7,350.3	8,228.6	10,019.4	11,150.9	11,012.0	-138.8
Бараа, үйлчилгээний зардал	3,133.3	3,141.4	3,327.5	4,000.5	4,785.5	4,958.1	4,440.7	-517.4
Цалин, хөлс	1,746.8	1,800.4	1,878.9	2,257.0	2,628.0	2,656.5	2,415.0	-241.5
Бараа, үйлчилгээний бусад зардал	1,386.5	1,341.0	1,448.6	1,743.5	2,157.5	2,301.6	2,025.7	-275.9
Зээлийн хүүний төлбөр	986.1	1,156.5	1,046.4	861.0	959.8	972.6	1,137.5	165.0
Татаас ба урсгал шилжүүлэг	2,494.4	2,745.3	2,976.4	3,367.1	4,274.1	5,220.2	5,433.7	213.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,360.2	1,658.1	1,680.4	3,016.7	3,806.1	3,408.0	3,498.5	90.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	521.3	316.0	286.5	416.4	47.1	18.6	-558.9	-577.5

Эх сурвалж: Сангийн яам (2020)

Ковид-19 цар тахлын эрсдэлийн эсрэг Засгийн газраас хэрэгжүүлж буй багц арга хэмжээний хүрээнд 2020 оныг дуустал нэмэгдүүлсэн хэмжээгээр олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмж (1.2 сая хүүхдэд 864 тэрбум төгрөг), халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн тэтгэмжийг 2021 оны эхний хагасыг дуустал хугацаанд үргэлжлүүлэн олгохоор төлөвлөсөн байна.

Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс улсын хэмжээнд нэвтрүүлэх, салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог дахин хуваарилах замаар цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгох зорилт дэвшүүлжээ. Мөн төрийн албан хаагчийн цалин хөлс, ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг 2020 оны түвшинд хадгалахаар тооцсон байна.

Төрийн албан хаагчийн гадаад, дотоод томилолт, хурал зөвлөгөөн, сургалт семинарын үйл ажиллагааг цахимжуулах замаар холбогдох зардлыг хэмнэхээр төсөлд тусгаснаас гадна цар тахлын эрсдэлтэй нүүр тулж ажиллаж байгаа төрийн байгууллагаас бусад төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг бууруулахаар, харин Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2021 онд 225.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 1,405.6 тэрбум төгрөгт хүргэх тооцоог хийжээ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэн хуулийн этгээдэд олгох улаан буудай, ноос, арьс шир, махны хүүгийн хөнгөлөлт, урамшуулалд нийт 65.3 тэрбум төгрөг тусгасан байна. Цаашдаа малын түүхий эдийн үнийн урамшууллыг зогсоож, бэлтгэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зээлийн эх үүсвэр, түүний хүүний зөрүүг санхүүжүүлэхэд зарцуулбал илүү үр дүнтэй байх болно.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон хүүхдийн мөнгийг 2021 оны сүүлийн хагас жилээс эхлэн цар тахлын өмнөх хэмжээнд хүртэл бууруулах бодлогыг хэрэгжүүлэхгүй бол төсөв, төрийн сан, банкны системээ эрсдэлд оруулах магадлал өндөр байна. Хүүхдийн мөнгөнд сар бүр ойролцоогоор 120.0 тэрбум төгрөг өгч байна. Энэ мөнгөөр хамгийн орчин үеийн 10 үйлдвэр барьж Монгол Улс нэмүү өртөг шингэсэн, дэвшилтэт технологид тулгуурлан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд гаргах боломжтой юм. Иймээс ирэх оны сүүлийн хагасаас хүүхдийн мөнгийг халамжийн болон бусад хуульд нийцүүлэн багасгаж, хэмнэгдэх мөнгийг ажлын байр бий болгох чиглэлд зарцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 1,384.0 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1,031 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Концессийн төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 224.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар тооцсон бол гадаадын зээл, тусламжаар 1,265.1 тэрбум төгрөгийн зээл, 150.3 тэрбум төгрөгийн тусламжийг авч ашиглан хөрөнгө оруулалт хийхээр тооцжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад багтсан эдгээр төслийн 62.3 хувь буюу 642 төсөл, арга хэмжээ нь өмнөх онуудад хэрэгжиж байсан шилжих хөрөнгө оруулалт бол 37.7 хувь буюу 389 төсөл, арга хэмжээ нь 2021 оноос шинээр хэрэгжихээр байна. Гэтэл шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 196 барилга, байгууламжийн 28.1 хувь буюу 55 төслийн зураг, төсвийг батлуулаагүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байгааг Үндэсний Аудитын газар судалж, гаргасныг онцгой анхаарах шаардлагатай. Зураг төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй, техникийн нөхцөл нь баталгаажгаагүй хөрөнгө оруулалтын төслийг УИХ-аар батлах нь “Төсвийн тухай” Монгол Улсын хуулийг зөрчөөд зогсохгүй, хэрэв батлагдсан тохиолдолд худалдан авах ажиллагаа нь хууль, тогтоомжийн дагуу төлөвлөсөн хугацаандаа хийгдэх боломжгүй болсноор төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашиг алдагдаж, төрийн үйлчилгээ цалгардах, иргэд үйлчлүүлэгчид хохирох муу нөлөөтэй. Иймд дээрх 55 төслийг 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс хасах хэрэгтэй.

Төсвийн хөрөнгө оруулалтыг улс орны хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болох “Алсын хараа 2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024 он)”, “Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”, 2021 оны улсын төсвийн төслийн баримт бичигт тусгагдсан бодлогын

зорилго, зорилтуудтай нягт уялдуулан тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн шийдвэр гаргадаг болох нь чухал.

Монгол Улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын зарим хэсгийг эдийн засгийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгоход чиглүүлэх ёстой. Иймээс улс орны хөгжлийн тэргүүлэх салбарын үйлдвэржилтэд Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн тодорхой хувийг зарцуулдаг байх шийдвэрийг УИХ, ЗГ-аас гарган хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь чухал юм. УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 9-ний өдөр “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн өөрчлөлттэй холбоотой тогтоол гаргасан бөгөөд энэ тогтоолд “Газрын хэвлийн баялаг ашигласны орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, түүнийг санхүүгийн үр ашиг бүхий төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, үнэт цаас гаргах зэргээр арвижуулах, Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах, шударгаар хуваарилах зарчмыг баримтлах, “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн зохицуулалтыг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нийцүүлэх” гэж тусгасан байна. Тухайлбал, жил бүр баялгийн сангаар бүрдэх хөрөнгөөс 1-2 их наяд төгрөгийг зөвхөн үйлдвэржилтэд зориулан гаргаж, ажлын байр бий болгож болохоор байна. Ийнхүү Үндэсний баялгийн сангийн хөрөнгөөр Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд хамаарах, үр ашгаа хурдан өгөх салбаруудын төсөлд хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэх юм.

2021-2022 онд багтаан дуусаагүй барилгыг бүрэн санхүүжүүлж дуусган цаашид хөгжлийн бодлогод тулгуурлан төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төслийг боловсруулж, эрэмбэ дараатайгаар шийдвэрлэн хэрэгжүүлж богино хугацаанд тухайн хөрөнгө оруулалтыг бүрэн санхүүжүүлж дуусгадаг болох (“Аманд ч үгүй, хамарт ч үгүй” байдлаар, “Эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй”-гээр олон төслийг зэрэгцүүлэн “дусал, дуслаар” олон жил хувааж санхүүжүүлэхийн оронд “Хийвэл сайн хий, хийхгүй бол огт битгий хий” гэсэн зарчмаар ажилладаг болох), улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын зардлын хязгаарыг салбар, аймаг, нийслэлээр тогтоон өгч тухайн хязгаарт нь багтааж хянадаг системд шилжих, төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орж буй төслийн ашиглалтын зардлыг төсөвт урьдчилан тооцож тусгадаг болох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

4. Төсвийн алдагдал, санхүүжүүлэх эх үүсвэр, улсын өрийн бодлого

Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2021 оны тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,154.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувьтай тэнцүү хэмжээний алдагдалтай байхаар төсвийн төсөлд тусгажээ. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №4: Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөг

Үр дүнгийн үзүүлэлт	2019	2020	2021
	Гүйцэтгэл	Тодотгол	Төсөл
ДНБ	35,331.3	38,688.3	42,230.1
Нийт орлого ба тусламжийн дүн	12,040.3	10,729.3	13,134.0
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	10,905.5	9,730.9	11,797.8
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,661.7	14,577.5	13,951.6
Төсвийн суурь тэнцэл	378.6	-3,848.2	-817.6
ДНБ-д эзлэх хувь	1.1	-9.9	-1.9
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-756.2	-4,846.6	-2,153.8
ДНБ-д эзлэх хувь	-2.0	-12.5	-5.1
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756.2	4,846.6	2,153.7
1.Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-1,103.4	0.0	150.9
2.ЗГ-ын үнэт цаас	-165.1	932.7	1,204.0
2.1. Урт хугацаат	-165.1	932.7	1,204.0
2.1.1. Дотоод	-165.1	932.7	1,596.4

2.1.1.1. Шинээр гаргах	0.0	1,195.7	2,166.0
2.1.1.2. Үндсэн төлбөр	-165.1	-263.0	-569.6
2.1.1.3. Худалдаж авах	0.0	0.0	0.0
2.1.2. Гадаад	0.0	0.0	-392.4
2.1.2.1. Шинээр гаргах	0.0	0.0	0.0
2.1.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0	-392.4
3.3Г-ын зээл	1,651.6	3,311.3	642.8
3.2. Гадаад	1,185.3	3,070.7	642.8
3.2.1. Төслийн зээл	777.2	748.7	346.8
3.2.1.1. Шинээр авах	1,215.5	1,472.9	1,265.1
3.2.1.2. Үндсэн төлбөр	-438.3	-724.2	-918.3
3.2.2. Хөтөлбөрийн зээл	408.1	2,322.0	296.0
3.2.2.1. Шинээр авах	408.1	2,322.0	296.0
4.Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	322.0	149.7	156.0
5.Өмч хувьчлал	1.0	0.3	0.0

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд шинээр 1,265.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл, 296.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл, 2,166.0 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод бонд гаргахаар тус тус төлөвлөжээ. Харин 150.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлтөөс, 156.0 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын санд хуримтлагдсан үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон байна. Өөрөөр хэлбэл алдагдлын дийлэнх хэсгийг өр үүсгэх замаар санхүүжүүлэх болж байна. Өр нэмэхгүй байх нь чухал.

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 61.9 хувьд хүрнэ гэж тооцоолсон байна. Өрийн хэмжээ ийм байдалтай боловч цаашид өр өсөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд хэрхэн давах вэ? гэдэг бодлогыг анхаарлын төвд байлгах хэрэгтэй. Ирэх жилүүдэд Засгийн төлбөр ихээхэн нэмэгдэнэ.

- Самурай бондын эргэн төлөгдөх хугацаа 2023 он бөгөөд 2021 онд 12.4 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөнө.
- БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл 2021 онд 79.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 8.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөнө.
- БОИНГ агаарын хөлөг худалдан авах төслийн гэрээнд заасан хуваарийн дагуу 2021 онд 24.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 1.2 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөнө.
- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Азийн Хөгжлийн Банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээлийн эргэн төлөлт 2019-2031 оны хооронд төлөгдөх хуваарьтайгаас 2021 онд 0.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 0.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдөнө.

Засгийн газрын зүгээс дээрх зээллэгийг зах зээлийн тохиромжтой нөхцөлд төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

2022 оноос Монгол Улсын Хөгжлийн банкны Синдикат зээл, Чингис бонд, МИК ОССК-ийн бонд, Гэрэгэ бонд, Самурай бонд, Хөгжлийн банкны бонд, БНХАУ-ын Ардын банкт хийсэн своп хэлцэл зэрэг томоохон дүнтэй үнэт цаас, зээлийг төлөх хуваарьтай байгаа тул санхүүгийн дансны дарамтыг бууруулахад анхаарах шаардлагатай байна.

3. ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. 2021-2023 онд Монгол Улсын эдийн засаг 6.0 хувиар өсөхөөр төсөөлжээ. Гадаад худалдааны эргэлт нэмэгдэж 2021-2023 онд гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум

ам.долларын ашигтай гарахаар төсөлд тусгагдсан байна. Үүний үр дүнд бий болсон хуримтлалыг зөв зүйтэй зарцуулах нь Засгийн газрын анхаарлын төвд байх ёстой. Тухайлбал Өмнийн говийн төмөр замын болон цахилгаан эрчим хүчний төслийг амжилттай хэрэгжүүлбэл жилдээ хамгийн багадаа 300-400 сая ам.долларын валютын хэмнэлт үүсэж, энэ хэмжээгээр эдийн засаг, санхүү төсөвт эерэг нөлөө үзүүлнэ. Нөгөө талд төлбөрийн урсгал тэнцэл алдагдалтай байгаа нь их хэмжээний гадаад зээлийн үндсэн өр хүүгийн төлбөртэй, маш олон төрлийн зөвлөх үйлчилгээ авдагтай, тээвэр, шатахууны зардал өндөртэй, түүнчлэн гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дотоодын ажил үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлд шингээх чадвар, хүчин чармайлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Төсөв, мөнгөний бодлогыг тодорхойлж эрэмбэлэхэд эхний ээлжинд экспорт, төлбөрийн тэнцлийг сайжруулахад анхаардаг олон улсын шилдэг туршлагыг авч хэрэглэх саналыг дэвшүүлж байна. Төлбөрийн тэнцлийн байдал, динамикийг хавсралт хүснэгт №5-д үзүүллээ. Хэрэв төсөөлж буйгаар эдийн засаг өсөлттэй, цар тахал намжвал төсвийн алдагдлыг “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д заасан хязгаарт багтаах зорилт тавих нь зүйтэй гэж үзэж байна.

2. Цаашид төсвийн зарлагын өсөлтийг хязгаарласан тохируулгыг “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д оруулах, ялангуяа сонгуулийн мөчлөгийн нөлөөг бууруулах тогтолцоог уг хуульд нэмж тусгах. Тухайлбал, санхүү, банк зэрэг мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр УИХ болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг дээд шатны байгууллагаас төсөв, зээл, төлбөрийн байдалд нөлөөлөх шийдвэрийг гаргахгүй байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Хууль зөрчсөн шийдвэр гаргавал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс вето-хориг тавьдаг эсвэл Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх зүйн боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй.

3. Төсвийн зарлагыг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүний нэг тулгамдсан асуудал нь төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй халамжийн бодлогыг шинэчилж хүрээ хязгаарыг хумих замаар нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал. Халамжийн бодлого хавтгайрсан байгаа талаар их шүүмжлэл гарч байгааг нэг бүрчлэн судлан үзэж, засаж залруулах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Төсөв, сангийн бодлогод зориуд анхаарч судлууштай зүйл бол цалин, хөдөлмөрийн эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, даатгал, татвар төлдөггүй хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох замаар ажил эрхлэгчдийн ирээдүйн нийгмийн баталгааг хангах явдал нэн чухал болно. Орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх бодлогын хүрээнд аймаг сум, хот дүүргийн төлөөллийн болон захиргааны байгууллагын зүгээс оршин суугчдын ажил эрхлэлтийг дэмжих санал санаачилга, хариуцлагыг цалин хөлсний бодлого, стратеги, төсөв хоорондын шинэчлэлээр дамжуулан нэмэгдүүлэх нь зүйтэй.

5. Багшийн цалин, урамшууллыг сурагчдын сурлагын амжилттай уялдуулан нэмэгдүүлэх ажлыг 2021 оноос эхлүүлж байгаатай холбоотойгоор нийт албан хаагчдын цалин хөлсний системийг ажлын бүтээмж, үр дүнтэй нь холбож, урамшууллын тогтолцоог шинэчлэх хэрэгтэй байна.

6. Зардлыг бууруулахын тулд хөрөнгө оруулалтын бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр “Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль”-д тодотгол хийх үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс санал өгсөн. Хөрөнгө оруулалтын бодлогыг

дахин сайтар харж үзэх, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудыг бэхжүүлснээр ард түмний эрүүл мэндийг сайжруулан боловсролын түвшинг нэмэгдүүлэх сайн тал байгаа ч эргээд төсвийн зарлагыг нэмэгдүүлдэг. Орон нутагт барьсан зарим сургуулиудын ашиглалт хангалтгүй суралцагчдын тоо хүрдэггүй байдал ажиглагдаж байна. Энэ байдалд дүгнэлт хийж хөрөнгө оруулалтын бодлогоо боловсронгуй болгох шаардлага байгааг анхаарч үзэх хэрэгтэй.

7. Монгол Улсын хамгийн хүнд асуудал бол зээлийн эргэн төлөлт. Төсөв өөрөө үүнээс хамаарна. Улсын төсөв, Төвбанк, арилжааны банкуудаас олгосон зээлийн эргэн төлөлтийн тухай асуудал. Ялангуяа томоохон, өр нь төлөгдөхгүй байгаа компаниудын жагсаалтыг гаргаж, үүнийг шийдэхийн тулд “нэмүү өртгийн сүлжээ” бий болгох хэрэгтэй. Өрөө төлж чадахгүй байгаа аж ахуйн нэгжүүдээс Монгол Улсын төрийн бодлогын хүрээнд төрийн өмчит компаниуд, төсвийн байгууллагууд бүтээгдэхүүнийг нь худалдаж авах, олон улсын зах зээлд нийлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар экспортыг өргөжүүлэх, дотооддоо нэмүү өртөг бүтээхэд онцгой анхаарах нь ач холбогдолтой.

8. Нэмүү өртгийн сүлжээ бий болгох тал дээр мал, махны бэлтгэлийг дагаж мөн арьс бэлтгэх асуудал яригддаг. Монгол Улсын хэмжээнд жилдээ 400-500 мянган тонн мах бэлтгэж, 200 гаруй мянган тонн махыг намар, зуны үед байнга хэрэглэнэ. Өвөл, хавар хэрэглэх, түүнчлэн экспортлох маханд эргэлтийн хөрөнгө бий болгож байж эдийн засгийн эргэлтийг сэлбэх нь зүйтэй. Нэмүү өртгийн сүлжээг албан эдийн засгаар бий болгож явдаг. Ковид-19 цар тахлын үед улс хоорондын хямд чанаргүй барааны бизнес хумигдаж, тендер шалгаруулалтад дотоодын үйлдвэрлэл ялах магадлалтай болж байна. Монгол Улсын төр жил бүр маш их мөнгөөр худалдан авалт хийдэг бөгөөд импортын барааны худалдан авалтыг өдгөө албан ёсны гэрээний үндсэн дээр хийх болж байгаа нь чухал алхам юм.

9. Малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос боловсруулах, хөнгөн үйлдвэрийн салбарт ажлын байр бий болгож, нэмүү өртөг бүтээж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолж байвал татвар авахыг урьтал болгох шаардлагагүй юм. Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс бага борлуулалттай татвар төлөгчдөд татварын хөнгөлөлт үзүүлсэн ч тэд техник технологио шинэчлэх, тоног төхөөрөмж авах, материал, түүхий эдээ татах эргэлтийн хөрөнгөгүй бол орон нутагт ажлын байр бий болгох боломжгүй болно. Иймээс Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдаж буй санхүүжилтийн 50-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд бага хүүтэй, эргэж төлөгдөх нөхцөлтэй зээл олгоход зориулж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, дахин ашиглах боломжийг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар бүрдүүлэх нь зүйтэй.

10. Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихийг урьтал болгох нь хүндрэлээс гарах хамгийн зөв зам байх болно. Төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрлэлээ дэмждэг олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлж чадахгүй байна. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс үзэхэд 4.4 их наяд төгрөгийг бараа, ажил үйлчилгээ худалдан авахад зориулан зарцуулахаар байна. Үүнээс гадна төрийн өмч бүхий цахилгаан станц, уурхай, эрчим хүчний зэрэг олон аж ахуйн нэгжүүд их хэмжээний худалдан авалт хийдэг. Монгол Улсын Засгийн газраас тендер шалгаруулахдаа дотоодын давуу эрхийг зайлшгүй тооцож байхыг төсвийн байгууллагууд, захиалагчдад үүрэг болгосон ч энэхүү давуу эрхийг тооцоход адилтгах импортын барааны үнийн зэрэгцүүлэлт хийх, барааны дотоодод үйлдвэрлэсэн гэсэн баталгаа, гарал үүслийн баталгаа зэргийг шаарддаг учраас дотоодын үйлдвэрлэгчдийг тэр бүр шалгаруулаад байдаггүй. Нөгөө талаар тендер

тойрсон хээл хахууль дотоодын үйлдвэрлэлд биш импортын сүлжээ (гадаадын нийлүүлэгчтэй үгсэн хуйвалдаж)-нд тулгуурладаг гэсэн шүүмжлэл байдаг. Эдгээр асуудлыг шийдвэрлэх хүртэл дотоодын үйлдвэрлэгчдээс шаарддаг олон шаардлагыг хүчингүй болгож, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг заавал ашиглах үүргийг бүх захиалагчид, барилгын ажил гүйцэтгэгчдэд өгөх нь зүйтэй.

11. Хэдийгээр урьдчилан тооцоолох боломжгүй, давагдашгүй хүчин зүйлийн улмаас төсвийн орлого тасалдаж, зардал нэмэгдэж байгаа боловч төсвийн сахилга батыг хадгалах, төсвийн алдагдлыг үргэлжлүүлэн бууруулах, Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх нь чухал юм. Үүний тулд төсвийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг болон урсгал зардлын уялдаа хангагдаж буй эсэхэд тооцоо, судалгаа хийж үнэлэн, чиг үүргийн дахин хуваарилалт хийхтэй уялдуулан холбогдох хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

12. Монгол Улс мал аж ахуйн түүхий эдийн 20 хүрэхгүй хувийг өөрсдөө бэлтгэж дотоод болон гадаад зах зээлд нийлүүлдэг. Энэ хувь хэмжээг цаашид нэмэгдүүлэх, Монгол Улсын хүн амын 1/3 болсон малчид, тэдгээрээс хамаарал бүхий иргэдийн орлогыг багасгахгүй байлгах явдал тулгамдсан зорилтын нэг юм. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө дутмаг, хүчин чадлаа бүрэн ашиглах хэмжээнд улирлын чанартай түүхий эдээ өндөр хүүтэй арилжааны зээлээр хангах нь тэдэнд туйлын эрсдэлтэй хэвээр байна. Нөгөө талаар Европ, Америк, Азийн ихэнх зах зээл удаан хугацаанд хаагдсан үед үйлдвэрлэл нэмэгдээд ч борлуулалт хязгаарлагдмал болно. Тухайлбал, ноолууран бүтээгдэхүүний томоохон зах зээлүүд түр хаагдсан байгаа. Тиймээс үйлдвэрлэлийг төдийлөн их биш зохистой түвшинд хадгалах, зээлийн эргэн төлөлт нь санхүүгийн эргэлтийн хөрөнгийн хүндрэлийг нэмэх тул зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах нь илүү зохистой дэмжлэг байх болно.

13. Хоёр хөрш болон бусад орнуудтай хийх худалдааг эрчимжүүлэх, чөлөөтэй болгох арга замыг холбогдох талуудтай хэлэлцэж нэн яаралтай шийдвэрлүүлэх, ялангуяа нүүрсний худалдааг нэмэгдүүлэх арга замыг тохиролцох хэрэгтэй.

14. Малаас гарах үндсэн түүхий эд болох 400 гаруй мянган тонн мах, 30 гаруй мянган тонн хонины ноос, 10-аад мянган тонн ямааны ноолуур, 15-аас доошгүй сая ширхэг арьс, ширний нөөц байна. Эдгээрийг цуглуулж эргэлтэд оруулна гэвэл ойролцоогоор 3 их наяд гаруй төгрөг буюу 1.1 тэрбум ам.доллар гарах юм. Мал аж ахуйн зарим түүхий эдийг бэлтгэж, боловсруулж, экспортод гаргахад зориулж 500.0 орчим тэрбум төгрөгийн зээлд 5 хувь нэгж хүүний хөнгөлөлтийг улсаас олгохыг санал болгож байна. Үүнд 25.0 орчим тэрбум төгрөг шаардагдана. Арилжааны банкууд Монгол Улсын Хөгжлийн банктай хамтран 13 хувийн хүү (бодлогын хүү 10 хувь, банкны зардлаа нөхөх хүү 3 хувь)-тэйгээр дурдсан зориулалтаар экспортлогч аж ахуйн нэгжид олгож, хэрэгжилтийг хангаж чадвал, үйлдвэрүүдэд зээлийн хүүний зөрүү 5 хувийг төсвөөс Хөгжлийн банкаар дамжуулан олгох хувилбар байж болох юм.

15. Төрөөс гадаад, дотоод эх үүсвэртэй зээлийн болон батлан даалтын сангуудын зарцуулалтыг дэмжихдээ экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох салбарын санхүүжилтэд чиглүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Дээр дурдсан санал, зөвлөмжийг төсвийн хэлэлцүүлгийн шатанд авч үзэхийг хүсч байна.

“УУЛ УУРХАЙ БА ОЮУН УХААН” ТАЙЛАН-ИЛТГЭЛИЙН ХЭСГЭЭС

2020 оны 09 дүгээр сар

ТТБЗ-ийн чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх. Үүнд: (i) чадварлаг хүний нөөцийг хангалттай хэмжээгээр, хараат бусаар бүрдүүлэх боломжийг хангах (ii) өөрийн үйл ажиллагааг хараат бусаар явуулахад шаардагдах санхүүгийн зохистой нөөцтэй болгох, (iii) төсвийн тогтвортой байдлыг шинжлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах эрхийг олгох зэрэг багтана.

Шигтгээ 2.3 Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үр дүнтэй ажиллахад түүний бие даасан байдал чухал үүрэгтэй болохыг бусад орны туршлага харуулж байна

Монгол Улсын шинээр байгуулагдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийн хараат бус байдлын талаар анхаарах хэд хэдэн асуудлууд байсаар байна. Монгол Улс болон бусад улс орнуудад хараат бус хяналтын чиг үүрэгтэй инститциудын түүхийг харгалзан үзвэл ТТБЗ-ийн өнөөгийн эрх зүйн хүрээнд түүний хараат бус байдал, төсвийн үйл явцад нөлөөлөх чадвар хангалттай бус; төсөв, хөрөнгө, хүний нөөцөөс шалтгаалан уг зөвлөлийн ажлын чанар сул байх; бусад институцитэй чиг үүргийн хувьд давхцах зэрэг улс төрийн хувьд шийдэх хэд хэдэн асуудлууд байна. Мөн уг зөвлөл нь хүний нөөцийн хувьд туйлын хангалтгүй (одоогийн эрх зүйн хүрээнд ердөө хоёрхон л ажлын албаны ажилтантай байхыг зөвшөөрсөн), орон тоогоо нэмэгдүүлэх бие даасан байдал үгүйлэгдэж байна. Ил тод байдлыг манлайлах, төсвийн бодлогын асуудлаарх хэлэлцүүлэгт олон нийтийн оролцоог дэмжих зэрэг ТТБЗ-ийн чадамжийн асуудал гол зовнил төрүүлж байна.

Амжилттай ажиллаж буй төсвийн тогтвортой байдлын зөвлөлүүдийн туршлагаас харахад хараат бус, ил тод байдал, макро эдийн засгийн тогтвортой байдлын ач холбогдлыг тайлбарлах, төсвийн бодлого, түүний хэрэгжилтийн талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх чадамж зэрэг асуудлууд чухлаар тавигдаж байна. Төсвийн бодлого, хэрэгжилтэд улс төрийн нөлөө орох байдал их ажиглагддаг ба төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус байдлыг сайтар хангах нь хамгийн чухал асуудал болоод байна. Уламжлалт төсвийн зөвлөлүүд нь нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал, тогтсон практикт илүүтэй суурилдаг байсан бол сүүлийн үеийн зөвлөлүүд хууль зүйн хувьд хараат бус байх тал дээр илүү анхаарч байна. ТТБЗ өөрийн үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд зохистой төсөв, санхүү шаардлагатай ба мөн хараат бусаар үйл ажиллагаагаа бүрэн явуулах чадамж нь нэн чухал юм. Мөн бусад орны туршлагаас харахад төсвийн зөвлөлүүд нь шаардлагатай мэдээллээ ямар нэгэн чирэгдэлгүй, хурдан шуурхай авдаг байх эрхээр хангагдаж, тэдний төсөв санхүүг хангалттай бүрдүүлж өгч байна.

Төсвийн бодлого, түүний хэрэгжилтэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс ТТБЗ нь төсвийн бодлогод өгч буй зөвлөгөө, шинжилгээгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр түлхүү дамжуулах явдал чухал юм. Аливаа төсвийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилттой уялдахгүй, таамаглал нь үндэслэлгүй, төсвийн зарлага, татварын бодлого, гүйцэтгэл төлөвлөснөөс ихээхэн зөрөх зэрэг олон чухал асуудлууд дээр ТТБЗ-ийн зөвлөгөө, шинжилгээ хамгийн чухал байх үүрэгтэй. Олон улсын туршлагаас үзэхэд ТТБЗ-ийн олон нийттэй үр дүнтэй харилцах байдал нь төсвийн тогтвортой байдалд мөн чухал үүрэгтэй болохыг илтгэж байна. 2000 оны

эхээр Голландын төсвийн зөвлөл нь төсвийн бодлогын үр дүн муудах тухай бүрд хэвлэлээр дамжуулан төсвийн бодлогын талаар үнэлгээ, зөвлөгөө өгч, мөн олон нийтийг мэдээллээр хангаж, төсвийн бодлогод үр дүнтэй нөлөөлсөн сайн жишээ байдаг.

Эх сурвалж: ОУВС 2013; Дэлхийн банк 2018f.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛЖУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

ЕХ Итгэлцлэлийн сангийн санхүүжилттэй Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төсөл

1. ОРШИЛ

Олон Улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ОУЭЗХАБ)-аас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) болон Парламентын Төсвийн алба (ПТА)-ыг хамтад нь Төсвийн бие даасан байгууллага (ТБДБ) гэж тодорхойлдог. ТБДБ нь “төсвийн бодлого болон түүний үр дүнд шинжилгээ хийх, хяналт тавих, зарим тохиолдолд зөвлөгөө өгөх үүрэг бүхий гүйцэтгэх засаглал эсхүл хууль тогтоох байгууллагын хууль ёсны эрх мэдлийн харьяалалын бие даасан төсвийн санхүүжилттэй байгууллага юм.”¹

ТТБЗ нь улсын санхүүг сахин хамгаалах чиг үүргийг хариуцан авсан хараат бус мэргэжлийн байгууллага болно. Тэдний гүйцэтгэсэн төсвийн бодлогын шинжилгээ нь төсвийн байдал болон улсын санхүүгийн тогтвортой байдлын зохистой эсэх талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг тойрсон тодорхой бус байдал (утаа)-ыг арилгахад тусална. Нөгөө талаас, ПТА нь Парламентын гишүүдийн хэрэгцээнд зориулан олон төрлийн шинжилгээг хараат бус байдлаар гүйцэтгэн Парламентад ажлаа тайлагнадаг төсвийн санхүүжилттэй бие даасан нэгж юм.

Үйлчлүүлэгийн чиг баримжаа, бүрэн эрхийн бүтэц болон байгууллагын загварын хувьд ТТБЗ болон ПТА нь харилцан адилгүй учраас нэг харьяалал дор дангаар эсхүл хоёр байгууллага зэрэг ажиллаж болно. Гэвч нэг харьяалал дор ТТБЗ болон ПТА хоёр байгууллага байх бол тэдний чиг үүргийн давхардлыг багасгаж, ажлын үр нөлөөг сайжруулахаар бие биенээ нөхөн ажиллах явдал амин чухал юм.

УИХ нь төсвийн шинжилгээний нэгж байгуулсан. Уг нэгж нь уламжлалт ПТА-тай адил чиг үүргийг гүйцэтгэж байна. Улмаар Монгол Улсын Засгийн газар, УИХ нь нөхөх чиг үүрэгтэй ТТБЗ байгуулахаар шийдвэрлэсэн. УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 83 тоот тогтоолоор ТТБЗ байгуулсан (уг тогтоолын хавсралтаар ТТБЗ-ийн дүрмийг баталсан). ОУВС-тай байгуулсан 3 жилийн хугацаатай өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн бүтцийн өөрчлөлтийн нэг шалгуур үзүүлэлт нь Монгол Улсад ТТБЗ байгуулах байсан.

2018 оны 9 дүгээр сард ТТБЗ-ийн дарга болон бусад гишүүдийг томилсон. Хүчин төгөлдөр тогтоолын хүрээнд ТТБЗ нь дарга болон 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. УИХ-ын Төсвийн байнгын хороо, ЗГХЭГ, болон Монголбанк тус бүр хоёр хүнийг тус зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлдэг. Үүнээс гадна хараат бус 3 гишүүнийг Төсвийн байнгын хорооны ажлын албанаас нээлттэй сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлнэ.

Зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдээс сонгох бөгөөд олонхийн санал авсан гишүүнийг томилно.

¹ Төсвийн бие даасан байгууллагуудын зарчмын талаарх Зөвлөлийн зөвлөмж (2014) ОУЭЗХАБ, Парис хот

ТТБЗ-ийн дүрмийн дагуу Зөвлөлийн гишүүдэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах, Зөвлөлийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах чиг үүрэг бүхий 2 хүнтэй ажлын албатай болно.

ТБДБ-ынн бүрэн эрхэнд уг байгууллагын чиг үүрэг, гүйцэтгэх үүргийг тодорхойлон зааж өгөх хэрэгтэй. ТБДБ нь доорх 6 төрлийн өргөн хүрээт чиг үүрэг, гүйцэтгэх үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- а. Ут хугацааны төсвийн тогтвортой байдлыг үнэлэх
- б. Макроэдийн засгийн эсхүл төсвийн төсөөллийг боловсруулах эсхүл нягтлах
- в. Төсвийн тусгай шаардлагын биелэлтэд хяналт тавих
- г. Парламентад төсвийн шинжилгээ хийж дэмжлэг үзүүлэх
- д. Бодлогын өртөг, зардал тооцох.
- е. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн өртөг зардлыг тооцох.

ОУЭЗХАБ-ын гишүүн орнуудын² ТБДБ-ын бүрэн эрхийг харьцуулсан шинжилгээнээс харахад ТТБЗ нь б. “макроэдийн засгийн эсхүл төсвийн төсөөллийг боловсруулах эсхүл нягтлах” , в. төсвийн тусгай шаардлагын биелэлтэд хяналт тавих” чиг үүргийг голчлон гүйцэтгэдэг. ПТА-тай хамтран гүйцэтгэдэг хоёрдугаар зэрэглэлийн ерөнхий чиг үүрэг бол а. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэх” юм.

Парламентын 2017 оны тогтоолын дагуу доорх бүрэн эрхийг ТТБЗ-д өгсөн. Үүнд:

- УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон төсөв санхүүгийн холбоотой бусад хуулийн төслийг судлан шинжилгээ хийх
- Дээрх баримт бичиг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэхийг хянан улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар тооцоо хийх
- Олон нийтэд төсвийн асуудлаарх мэдээлэл хүргэх, төсвийн ил тод байдлыг хангах
- Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны хүсэлтийн дагуу тодорхой асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах
- Өөрийн гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороонд хүргүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлэх.

Энэхүү бүрэн эрхэд суурилан Монгол Улсын ТТБЗ нь дээр дурдсан өргөн хүрээт 6 чиглэлийн 4 чиглэлд төвлөрөн ажиллах үүрэгтэй. Эдгээр нь а,б,в гэсэн чиг үүрэг болон г. “УИХ-д төсвийн шинжилгээний дэмжлэг үзүүлэх” болно.

ТТБЗ нь Улсын Их Хуралд төсвийн төслийг өргөн мэдүүлснээс хойш 15 хоногт багтаан шинжилгээ хийн санал дүгнэлт гаргах үүрэгтэй. ТТБЗ нь шинжилгээний үр

² ОУЭЗХАБ-ын мэдээлэлд суурилсан

дүн, дүгнэлтийг УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ба хүргүүлснээс хойш 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ. Одоогийн эрх зүйн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хороо нь ТТБЗ-ийн зөвлөмжийг дагах үүрэггүй боловч зөвлөмж нь тус байнгын хорооны хэлэлцүүлэг, шийдвэр гаргахад мэдээлэх өгөх, чиглүүлэх зорилготой.

ПТА нь энэ чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй боловч ТТБЗ нь энэ чиг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан байхгүй юм. Гэвч ТТБЗ, ПТА аль алиныг байгуулсан улс орны хувьд уг байгууллагуудын чиг үүргийг давхардуулахгүй байх, ажил үүргийг уялдуулан зохицуулах явдал чухал юм.

2. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛЖУУЛАХАД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ, БОЛОМЖ

УИХ-ын Төсвийн Байнгын хороо болон Сангийн Яамнаас саяхан байгуулагдсан ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах явдал нь Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг гэж онцлон үзэж байна. Шинээр байгуулагдсан тус зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй тогтмолжуулах, суран дадлагажих эхний үеийг даван туулахад Зөвлөлийн гишүүд, УИХ, төрийн холбогдох бусад байгууллагуудын ажиллагсад техник туслалцаа үзүүлэх нь чухал гэж үзэж буйгаа Засгийн газар Дэлхийн Банкинд илэрхийлсэн.

ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулахад иж бүрэн хандахын тулд зөвлөлийн загвар, зохион байгуулалтын доорх 4 асуудлыг нарийвчлан авч үзэхийг шаардаж байна. Үүнд:

- А. Орчин** (өөрөөр хэлбэл, ТТБЗ бүрэн эрхээ хэрэгжүүлэх улс төр, зохион байгуулалтын орчин)
- В. Орц** (өөрөөр хэлбэл, ТТБЗ-ийн бүтээмж, гарцыг нэмэгдүүлэх эсхүл хязгаарлах зохион байгуулалтын нөөц)
- С. Процесс** (өөрөөр хэлбэл, гарцыг бий болгохын тулд мөрдөх бизнес\ ажлынурсгал процесс);
- Д. Гарц** (өөрөөр хэлбэл, ТТБЗ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ)

ТТБЗ-ийн хөгжлийн эхний алхам бол уг байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах явдал юм. ТТБЗ тогмол үйл ажиллагаа явуулмагц Зөвлөлийн анхаарал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник чадавхыг бэхжүүлэхэд төвлөрнө. Өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд ТТБЗ-ийн гол бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхой болгох нь ТТБЗ-өөс эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах шинжилгээний чадвар, аргачлалыг нарийвчлахад тусална. Хийгдэх шинжилгээний төрлөөс хамаарч Засгийн газрын байгууллагатай хэлэлцэн тохирох мэдээлллийн протоколын агуулга тодорно.

ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах 4 бүрэлдэхүүний талаар доор дэлгэрэнгүй өгүүлэв. Үүнд:

А. Орчин

ТТБЗ-ийн оршин тогтнох хууль эрх зүй, улс төрийн орон зайн асуудалд ТТБЗ-ийн үйл ажиллагааны энэ бүрэлдэхүүн төвлөрнө. Бусдаас ТТБЗ-ийн хувьд

тодорхойлж өгсөн бүрэн эрх, чиг үүрэг (өөрөөр хэлбэл, албан ёсны бүрэн эрх)-ийг нарийвчлан авч үзэх, олгогдсон бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ТТБЗ зохион байгуулалтын ямар арга хэмжээ (жишээлбэл, ТТБЗ-ийн албаны засаглал, ТТБЗ-ийн удирдлага, ТТБЗ-өөс гол оролцогч талуудтай харилцах харилцаа) авах шаардлагатай тодорхойлох хэрэгтэй.

ТТБЗ нь бусад гол талуудтай харилцах харилцааг тодорхойлоход хэд хэдэн хэрэгсэл, тухайлбал, харилцан ойлголцлын санамж бичиг, үйлчилгээний гэрээ, дүрэм зэргийг ашиглаж байна. Санамж бичиг нь хоёр болон түүнээс дээш талууд хоорондын гэрээ болох албан ёсны баримт бичиг юм. Энэ нь хууль зүйн хувьд заавал биелүүлэх үүрэг бус ч уг баримт бичигт тодорхойлсон үүргийг хэрэгжүүлэх эрмэлзлээ илэрхийлэн гарын үсэг зурдаг. Уг баримт бичигт маргааныг шийдвэрлэх заалтыг тусгаж өгч болно. Хамтын зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө ажиллахад хүлээх үүрэг хариуцлагын талаарх ерөнхий ойлголтыг уг баримт бичигт тусгадаг.

Үйлчилгээний гэрээ нь Санамж бичгийн адил хоёр болон түүнээс дээш талууд хоорондын гэрээ юм. Гэвч, харилцан үүргийг тодорхойлсон Санамж бичигтэй адилгүйгээр Үйлчилгээний гэрээ нь нэг тал нөгөө талдаа юу хийхийг л зааж өгдөг. ТТБЗ нь нөгөө талдаа харилцан үүрэг хүлээлгүйгээр нөгөө талаас орц техайлбал, мэдээллээр хангах эсхүл нөгөө талд үйлчилгээ эсхүл гарц техайлбал, шинжилгээ хийх үүрэг хүлээсэн тохиолдолд энэ хэрэгслийг ашиглаж болох юм.

Гэтэл Дүрэм нь албан эсхүл албан бус байж болно. Албан ёсны дүрэм нь шинээр байгууллага үүсгэн байгуулахад байгуулдаг. Албан бус дүрмийг үйл ажиллагаагаа эрхэлж буй байгууллага, тухайлбал, ТТБЗ нь өөрийн эрх мэдлийн хүрээнд ямарваа зүйл хийх эсхүл зан авир гаргах эрмэлзлийг бий болгоход голчлон хэрэглэдэг. Ийм төрлийн дүрэм нь харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахад хэт олон буюу тодорхой бус тооны талуудын бүлэглэлд чиглэсэн байдаг. Ерөнхий жишээ бол байгууллагын үүрэг, иргэдэд үйлчлэх ерөнхий эрмэлзлийг харуулсан Иргэдийн дүрэм юм.

УИХ-ын Төвсийн бөйнгын хорооны 2017 болон 2019 онуудны тогтоолоор ТТБЗ-ийн албан ёсны эрх, үүргийг тогтоосон шиг энэ хэсэгт орчинд анхаарна.

(i) ТТБЗ-ийн Ажлын албаны засаглал

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр баталсан тогтоолоор ТТБЗ-ийн ажлын хүрээ, хуралдаан зохион байгуулалт, төсөв, хүний нөөц зэрэг бүтэц, зохион байгуулалтын асуудлыг тодорхойлсон. ТТБЗ нь Зөвлөл болон зөвлөлд дэмжлэг үзүүлдэг ажлын алба гэсэн хоёр бие даасан байгууллага болж ажилласнаар үйл ажиллагаа үр дүнтэй байдаг. Энэ нь Парламентын байнгын хороо болон түүний ажилд дэмжлэг үзүүлдэг ажлын алба хоорондын харилцаатай төстэй юм.

Зөвлөлийн чадварлаг алба нь зөвлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын дэмжлэгээс гадна шинжилгээний дэмжлэг үзүүлдэг. Одоогоор Монгол Улсын ТТБЗ нь 2 хүнтэй ажлын албатай бөгөөд зөвлөлийн гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангах, гишүүд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах

дэмжлэгийг үзүүлдэг. Зөвлөлийн гишүүд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангахад бүхий л хэлбэрийн шинжилгээ орох бол Зөвлөлийн ажилтнуудад тавих шаардлагат энэ чадавхийг оруулж өгөх нь чухал юм.

Зөвлөлийг техник шинж чанартай орцоор хангах эсэхээс үл хамаарч Зөвлөлийн ажлын албаны засаглалын бүтцийг тогтоох нь ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай эхний алхамын нэг болно. Үүнийг стратегийн төлөвлөгөө боловсруулах явцад боловсруулсан Стратегийн төлөвлөгөөнд голчлон тусгаж өгдөг.

(ii) Зөвлөлөөс гол үйлчлүүлэгчид болон түншүүдтэй харилцах харилцааг тодорхойлох

Аливаа ТТБЗ нь төсвийн ил тод байдлын өргөн хүрээт орчинд оршин тогтнодог. Гол үйлчлүүлэгч болон түнш нартай байгуулсан Үйлчилгээний гэрээ эсхүл Харилцан ойлголцлолын санамж бичигт оролцогч талуудын чиг үүрэг, хүлээх үүрэг болон хоорондын харилцааг хэрхэн зохицуулан удирдахыг тодорхой болгож өгнө. ТТБЗ-өөс төрөл бүрийн хэрэгслийг ашиглан доорх нэмэлт гэрээг эцэслэн байгуулах асуудлыг авч үзэж болно. Үүнд:

Монголбанк & Сангийн яам: Монгол Улсын ТТБЗ нь Монголбанк болон Сангийн яамтай байгуулах Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулсан. Санамж бичгийн төсөлд юу тусгасан нь тодорхой бус байгаа ч хэрэв санамж бичигт харилцан хүлээх үүргийг тусгаж өгөөгүй бол ТТБЗ-өөс уг баримт бичгийг үйлчилгээний гэрээ болгон өөрчлөх асуудлыг авч үзэж болно.

Төсвийн шинжилгээний нэгж: Түүхийн үүднээс Парламентын төсвийн шинжилгээний алба нь төсвийн ерөнхий байдал, төсвийн шаардлагыг хангаж буй байдал, макро төсөөлөлд хийсэн шинжилгээгээр УИХ-ын Төсвийн байнгын хороог хангаж ирсэн. ТТБЗ нь харьцангуй шинэ байгууллага учраас дундын үе шатанд Төсвийн шинжилгээний нэгж ТТБЗ-ийн албанд үйл ажиллагааны болон шинжилгээний дэмжлэг үзүүлж байна. Үүнд ТТБЗ-ийн гишүүдийг төсвийн байдал, төсвийн шаардлагыг хангаж буй байдал болон төсөөлөлд хийсэн шинжилгээний үр дүнгээр хангах явдал орж байна.

Нэг орон зайд ПТА болон ТТБЗ-тэй байхын үр ашиг байна. Гэвч, давхардлаас зайлсхийх, боломжит үр нөлөөг дээд хэмжээнд хүргэхийн тулд тэдгээрийн чиг үүрэг, хүлээх хариуцлага, тайлагналын зохион байгуулалтыг зааглах нь чухал болно. ПТА нь төсвийн орлого, зарлага, бодлогын өртөг зардлын шинжилгээнд голчлон төвлөрдөг бол ТТБЗ нь төсвийн ерөнхий байдал, төсвийн шаардлагыг хангаж буй байдал болон макро таамаглалыг авч үздэг. Эдгээр байгууллагын гүйцэтгэх үүрэг, хүлээх үүргээс үл хамааран гүйцэтгэх ажлыг давхардуулахгүй байх ёстой. Байгууллага тус бүрийн гүйцэтгэх шинжилгээний төрлийн зааг, хэзээ мэдээлэл хуваалцан хамтран ажиллах асуудлыг Харилцан ойлголцлын санамж бичигт тусгах шаардлагатай.

Иргэний байгууллага & Иргэд: ТТБЗ болон иргэний нийгэм хооронд хамтын ажиллагааны харилцааг бий болгох нь иргэний нийгмийн

байгууллагын гүйцэтгэсэн тусгайлсан салбарын шинжилгээ, томоохон шинжилгээний бүтээгдэхүүний тэднийг шүүмжлэгчээр ажиллуулах, ТТБЗ-ийн бүтээгдэхүүн, мэдээллийг өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх хөшүүрэг болох зэрэг боломжуудыг олгодог. Австралийн ПТА зэрэг зарим ТБДБ нь төсөвлөлт, төсвийн бодлогын талаар олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх тодорхой бүрэн эрхтэй байдаг. ТТБЗ нь Иргэний дүрэм гэх мэт үйлчилгээний ерөнхий гэрээнд иргэний нийгэм, иргэдтэй байгуулах харилцааны мөн чанарын талаарх өөрийн хүлээлтийг тодорхойлон тусгах шаардлагатай.

(iii) Итгэлцэл\ найдвартай байдал

ТТБЗ-өөс боловсруулсан төсвийн бодлогын шинжилгээ, үнэлгээ нь Засгийн газрын төсвийн олон нийтийн хэлэлцүүлэг тойрсон тодорхой бус байдал (зорьсон эсхүл зориогүй)-ыг арилгахад тусална. Энэ чиг үүргийг гүйцэтгэхийн тулд ТТБЗ-ийн шинжилгээ нь гол оролцогч талууд болон олон нийтийн итгэлийг авсан найдвартай байх хэрэгтэй. Итгэлцлийг бий болгох амин чухал бүрэлдэхүүн бол ТТБЗ төсвийн гол оролцогчдоос бие даасан байх явдал юм. Төсвийн оролцогч нар ТТБЗ-ийн шинжилгээнд шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх эсхүл нөлөөлсөн байх гэсэн байдал үүсгэхгүй байхыг хангана гэсэн хэрэг юм.

Монгол Улсын шинээр байгуулагдсан ТТБЗ нь УИХ, Сангийн яам, Монголбанк болон бусад байгууллагын төлөөллөөс бүрддэг. ТТБЗ-ийн өмнө тулгарч буй сорилт бол Зөвлөлийн бүрэлдэхүүнд төсвийн гол оролцогчид оролцсон нөхцөлд түүний бие даасан байдлыг хэрхэн хангах явдал юм. Монгол Улсын ТТБЗ өөрийн шинжилгээний бие даасан байдалд итгэл төрүүлэхийг хүсвэл өөрийн гарцыг бүтээхэд ашигласан аргачлал, мэдээлэлтэй холбогдсон төдийгүй ТТБЗ-ийн үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой хүчтэй, найдвартай ил тод байдлыг журмыг мөрдөн хэрэгжүүлэх ёстой. Өндөр түвшиний ил тод байдал нь ТТБЗ-ийн гарцын найдвартай байдлыг бэхжүүлэх, түүний үйл ажиллагаа эсхүл илрүүлсэн зүйлд аливаа нөлөөлөл эсхүл нөлөөлөл орсон гэж үзэхээс хамгаалахад туслана.

Урт хугацаандаа эдгээр байгууллагын төлөөлөл Зөвлөлд шууд томилогдон ажиллахаас татгалзах асуудлыг авч үзэж болох юм. Энэ нь ТТБЗ-ийн гарц нь бүрэн бие даасан бөгөөд ийм учраас найдвартай гэсэн олон нийтийн дундах ойлголтыг бататгахад туслана.

(iv) Мэргэжлийн Сахилгын дүрэм

Байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу ТТБЗ-д мэдээллийг сайн дурын үндсэн дээр эсхүл албан хүсэлтийн дагуу өгөхөөс үл хамааран зарим мэдээ/мэдээлэл нууцын зэрэглэлтэй байна. ТТБЗ нь нууцын зэрэглэлтэй эсхүл хувийн мэдээлэл хэрхэн ашиглах, тараах эсхүл хэвлэн нийтлэх бол гэсэн болгоомжлолоос сэргийлэхийн тулд Зөвлөлийн хэрэгцээнд гарган өгсөн хувь хүн, албан байгууллагын мэдээллийн нууцлалтыг хамгаалах тухай заалтыг Дүрмэнд тусгаж өгөх шаардлагатай.

ТТБЗ-ийн гишүүд болон ажлын албаны ажилтнуудын сахилгын дүрмэнд тэдний мөрдөх ёс зүйн дүрэм түүний дотор хувийн эсхүл мэдрэмжтэй

мэдээллийн талаар хүлээх хариуцлагыг тогтоож өгнө. Сахилгын дүрмийг өргөжүүлсэн сошиал медиа баримтлах удирдамж нь ТТБЗ-ийн гишүүн, ажлын албаны ажилтан байх явцдаа хувийн сошиал медиа хэрхэн ашиглах талаарх хүлээлтийг тогтоож өгнө.

В. Орц

ТТБЗ-ийн бүтээмж, гарцыг нэмэгдүүлэх эсхүл хязгаарлах зохион байгуулалтын нөөцийг орц гэж тодорхойлж болно. Анхдагч орц нь хүний нөөц, мэдээ, мэдээллийн хүртээмж, технологи болон төсөв болно. Эдгээрийг дор өгүүлэв. Үүнд:

(i) Хүний нөөц

Өнөөгийн байдлаар ТТБЗ-ийн ажлын алба нь зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй 2 ажилтантай. ТТБЗ-ийн ажлын алба тус зөвлөлийн хэлэлцүүлэгт зориулан шинжилгээний дэмжлэг одоогоор үзүүлдэггүй байна. Дунд хугацаанд ажлын албанаас зөвлөлд дэмжлэг үзүүлэхэд ямар чиг үүрэгтэй байх нь тодорхой бус байна.

ТТБЗ амжилттай үйл ажиллагаа явуулах хамгийн чухал орц бол хүний нөөц юм. Үүнд Зөвлөлийн гишүүд, албаны ажилтан хамаарна. ТТБЗ-ийн ажлын алба нь Зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэх Стратегийн төлөвлөгөөг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай зохих чадамж, чадвартай ажилтнуудтай байх ёстой. Зөвлөлийн ажлын албанаас гишүүдэд шинжилгээнээс гадна зохион байгуулалтын дэмжлэгийг үзүүлэх эсэхийг Зөвлөл тодорхойлох хэрэгтэй. Ажлын албаны гүйцэтгэх үүргийг тодорхой болгох нь хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулах боломжийг олгоно. Хүний нөөцийн төлөвлөгөө нь Стратегийн төлөвлөгөөнд суурилсан байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлно. Үүнд ажилтны тоо, тэдний ажлын байрны тодорхойлолт, үүргийг оруулах ба шаардлагатай ажил мэргэжлийн шаардлагыг багтаана.

(ii) Мэдээлэл/ Мэдээ

Монгол Улсын ТТБЗ нь өөрийн бүрэн эрхийн дагуу хүлээгдэж буй шинжилгээг хийхэд шаардлагатай бүх мэдээллийг авах боломжоор хангагдаагүй байна. Чанартай хараат бус шинжилгээг хийхийн тулд Засгийн газрын ашиглаж буй бүхий л мэдээ, мэдээллийг хязгааргүй эрхтэйгээр авах шаардлага ТТБЗ-д байна.

Засгийн газрын Санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сангийн тухай мэдээлэлтэй байх, уг сангаас мэдээлэл татах, тайлан гаргаж авах боломжоор хангагдсан байх хэрэгтэй. Бусад мэдээллийг уян хатан\засварлах хэлбэр тухайлбал, Excel болон Word програмыг ашиглан ТТБЗ-д шууд гаргаж өгөх хэрэгтэй. Үүнээс гадна ТТБЗ нь зохистой гуравдагч талын мэдээллийг эх сурвалж болгох шаардлагатай.

ТТБЗ-өөс тогтоосон боломжийн хугацаанд мэдээлэл, баримт бичиг, мэдээг тодорхой хэлбэрээр хэвлэсэн байхыг шаардах, биелүүлэх эрх мэдлийг

байгууллагын бүрэн эрхэд хамруулна. Онолын хувьд ТТБЗ нь үр ашгийг сайжруулах үүднээс энэхүү эрхээ эдлэх боломжтой байх ёстой. Гэвч, УИХ-ын албадлын эрх мэдлийг ашиглах замаар л хэвлүүлэх боломжтой бол УИХ-ын Төсвийн байнгын хороогоор дамжуулан гадаад эх үүсвэрээр баримт бичиг шаардах боломжийг ТТБЗ-д олгосон тодорхой процессийг тогтоох шаардлагатай болно.

ТТБЗ-д олгогдсон эрх мэдлээс үл хамааран тогтмол эсвэл үе үе боловсруулж байдаг зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хадгалдаг гол оролцогч талуудтай мэдээллийн протокол боловсруулах замаар өгөгдлийг автоматаар хэвлэхэд хялбар болгоно. Шаардлагатай мэдээллийг автоматаар хэвлэх\ян хатан хэлбэрээр автоматаар дамжуулах нь ТТБЗ-ийн гишүүд нөгөө байгууллага хариу өгөхийг хүлээлгүйгээр өөрсдийн гарцаа бэлтгэхэд үр дүнтэй байдлыг бий болгоно. Ялангуяа давчуу хугацаанд гол шинжилгээ хийх үүрэгтэй ТТБЗ-ийн хувьд илү тохиромжтой юм.

(iii) Төсөв

ТТБЗ-ийн амжилтын чухал хүчин зүйл нь нөөцийн хувьд бие даасан байдал юм. Монгол Улсын ТТБЗ нв өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагатай төсөвтэй, өөрийн төсвөө хянан зарцуулах, ажилтнаа сонгон ажилд авах эрхтэй байх ёстой. ТТБЗ-ийн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж буйд хяналт тавих УИХ-ын Төсвийн байнгын хороо гэх мэт төсвийн үйл явцын манлайлагчтай байх ёстой. ТТБЗ нь төсвийн хөрөнгийг зохистой ашигладаг байгууллага гэсэн итгэлцлийг оролцогч талуудын дунд болон иргэдийн зүгээс авах үүднээс хөндлөнгийн аудитын байгууллагаар тогтмол аудит хийлгэх шаардлагатай.

(iv) Технологи

ТТБЗ үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад шаардлагатй технологийн дэд бүтэц, системийг худалдан авах хөрөнгөөр хангагдсан байх шаардлагатай. Үүнд шаардлагатай шинжилгээг гүйцэтгэхэд хангалттай чадалтай компьютер, том хэмжээний мэдээг хадгалах хувилбарын механизм (үүлэн технологи гэх мэт), шинжилгээ гүйцэтгэхэд шаардлагатай програм хангамж (ялангуяа,таамаглалын програм хангамж) болон Зөвлөлийн гишүүд болон албаны ажилтнууд байршлаас үл хамааран виртуал орон зайд тогтмол найдвартай уулзах боломжийг хамруулна. Энэ нь Улаанбаатар хотын суурьшлын бус зөвлөлийн гишүүдийг хамруулах хувилбарыг ТТБЗ авч үзэх явдлыг мөн хангана.

С. Процесс

Шинэ ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулахад гол бүрэлдэхүүн бол процесс юм. Бизнес/ажлын урсгал процесс нь тогтвортой гарц эсхүл үр дүн гаргахын тулд гүйцэтгэх хэрэгтэй дотоод үе шатыг стандартжуулдаг. Процесс нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг дэмжих хэрэгтэй бөгөөд үйл ажиллагааны зааварт ихэвчлэн албажуулдаг/кодчилдог.

Процессууд нь шинэ ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогмолжуулах гол бүрэлдэхүүн юм. Бизнес / ажлын урсгалын процесс нь тууштай гарц эсвэл үр дүнг бий болгохын тулд дотоод үйл ажиллагаа\алхамыг стандартчилдаг. Процессууд нь Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжиж, үйл ажиллагааны гарын авлагад ихэвчлэн бүртгэгдсэн / кодчилсон байх ёстой.

Стандарт бизнес/ажлын урсгал процесст доорх зүйл багтдаг.Үүнд:

- Үйлчлүүлэгч ТТБЗ-д шинжилгээний хүсэлт/саналыг өргөн мэдүүлэхэд ашиглах маягт, протокол
- Оролцогчдоос хүлээн авсан шинжилгээний хүсэлт/саналыг оруулах болон эрэмбэлэх протокол
- ТТБЗ дээр хийгдэх шинжилгээ бүрийг гүйцэтгэхээр хэрэгжүүлэх дотоод үе шатыг стандартжуулах (шинжилгээний хүсэлтийг оруулах эсхүл бүтээгдэхүүнийг хэвлэх болон тараах гол үр дүнг эхлүүлэх)
- Шинжилгээний хэрэгцээг хангах үүднээс хязгаарагдмал нөөцийг үр дүнтэй удирдахад туслах үүднээс төрөл бүрийн бүтээгдэхүүн гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, орцыг тодорхойлох хугацаа бүртгэлийн протокол
- ТТБЗ-ийн шинжилгээний бүтээгдэхүүний загварын удирдамж (инфограф ашиглахыг оруулан)
- Хэвлэлийн протокол.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах удирдамж

D. ГАРЦ

ТТБЗ-өөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж буй бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээг гарц гэнэ. Бүтээгдэхүүн нь шинжилгээний тайлан, зөвлөмж, танилцуулга, мэдлэгийн бүтээгдэхүүн, инфограф, мэдээллийн багц, болон жилийн тайлан гэсэн хэлбэртэй байж болно.

ТТБЗ-ийн үндсэн гарцыг тодорхойлсноор Зөвлөлийн удирдлага нь:

- Байгууллагын эрх мэдлийн шаардлагыг хангаж байгааг хянах
- Хүний нөөцийн бодитой төлөвлөгөө бэлтгэж, төсвийн зохих төсөл боловсруулах
- Жилийн төсвийн төлөвлөлтийн үйл явцын тодорхой үе шатанд тодорхой төрлийн шинжилгээ, судалгааг олон нийтэд хүргэх бие даасан найдвартай эх үүсвэр болж үйлчлүүлэгчид болон нийгмийн дунд итгэлцлийг бий болгох
- Байгууллагын бүрэн эрхийн талаар тавьсан шаардлагыг хангаж буйг нягтлан шалгах
- Хүний нөөцийн бодитой төлөвлөгөө, зохистой төсвийн төсөл боловсруулах
- Жилийн төсөвлөлтийн тодорхой үе шатанд олон нийтэд хүргэдэг тодорхой төрлийн шинжилгээний бие даасан, найдвартай эх сурвалж хэмээгдэн үйлчлүүлэгчдийн дунд болон олон нийттэй итгэлцлийг бий болгох.


ТТБЗ-ийн гарцын хувьд тэр бүрий авч үздэггүй гарц бол түүний жилийн тайлан байдаг. ТТБЗ-өөс өөрийн ажлын үр нөлөөг хэмжих, үр дүнг үнэлэх механизмыг хөгжүүлэх хэрэгтэй. Үүнд боломжит нөлөөг тодорхойлох, зорилтот үзүүлэлтийг тогтоох, байгууллагын өөрчлөлтийн онолтой холбогдох мэдээллийг байнга цуглуулах, зорилтот үзүүлэлтийг хангаж буйд тогтмол үнэлгээ хийхийг хамруулна. ТТБЗ-өөс УИХ, Засгийн газар, Монголбанкинд хүргүүлж, өөрийн цахим хуудсанд тавьсан жилийн тайланд эдгээр мэдээллийг тусгасан байна.

Монгол Улсын ТТБЗ-ийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх хөндлөнгийн механизм мөн бүрдсэн байх ёстой. Хөндлөнгийн зөвлөх, байнгын зөвлөх хэсэг\алба эсхүл төлөвшсөн өөр ТТБЗ-өөс хийсэн хөндлөнгийн үнэлгээ хэлбэртэй байж болно.

3. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛЖУУЛАХ ЗАМЫН ЗУРАГ

ТТБ Зөвлөлийн хэв загвар, бүтэц зохион байгуулалтын 4 бүрэлдэхүүн (өөрөөр хэлбэл, орчин, гарц, процесс, орц)-ний хувьд ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах замын зураглалыг гаргаж, шат дараатай авах алхам болгон зохион байгуулна. Бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар хийгдэх өөрчлөлтийн нэгтгэсэн үйл явцыг доорх зурагт харуулав. Дараалсан зарим алхамыг нэг зэрэг авч болно. Монгол Улсын ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах үе явцын одоогийн үе шатыг шар өнгөөр тодотгосон.

ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах Замын зураг



4. ДАРААГИЙН АЛХАМ

ТТБЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай шат дараалсан арга хэмжээ, шинэчлэлийн Замын зургийг Хавсралт 1- Санал болгож бжй арга хэмжээний матриц харуулав.

Хавсралт 1
Хэрэгжүүлэхээр санал болгож буй үйл ажиллагаа ба үр дүнгийн матрикс
I үе шат: 2020

Үйл ажиллагаа	Хариуцан эзэн	RETF-н оруулах хувь нэмэр (2019-2020 оны ажлын төлөвлөгөөний дагуу)	Хугацаа	Эцсийн бүтээгдэхүүн/ Үр дүн
1. Стратеги				
<p>Төсвийн зөвлөлийн стратеги төлөвлөгөөг бэлтгэх стратеги төлөвлөлтийн үйл явцыг явуулах.</p> <p>Стратеги төлөвлөгөө нь байгууллагын зорилго (алсын хараа гэх мэт), өөрчлөлтийн онол, үнэт зүйлээ тодорхойлох, шинэ Зөвлөл болон Ажлын албаны засаглалын зохицуулалтыг тогтоох, зорилго зорилтоо хэрэгжүүлэхийн тулд тус төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх тухай тусгах ёстой.</p> <p>Стратеги төлөвлөгөө нь Төсвийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ба ялангуяа хүрэх эцсийн үр дүнг тодорхойлсон байна. Эцсийн үр дүн буюу бүтээгдэхүүн нь үйлчлүүлэгчиддээ зориулан гаргасан Төсвийн зөвлөлийн бүтээгдэхүүн байна. Энэ эцсийн бүтээгдэхүүн нь аналитик дүн шинжилгээний тайлан, зөвлөмж, товч баримт бичиг, мэдлэгийн бүтээл, инфографик, мэдээллийн багц, жилийн ажлын тайлан зэрэг хэлбэртэй байж болно.</p>				<ul style="list-style-type: none"> • ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ Стратеги төлөвлөгөө

2. Ажиллах хүчний төлөвлөлт

Ажлын албаны засаглалын зохион байгуулалтыг Стратеги төлөвлөгөөнд тусгах ёстой. Үүнд Ажлын албаны чиг үүрэг, байгууллагын загвар дизайн, эрх бүхий ажилтнуудын удирдлагын эрэмбэ зэргийг дурдсан байна. Сайн зохион байгуулалттай Төсвийн зөвлөлийн Ажлын алба нь үйл ажиллагааны болон захиргааны дэмжлэг үзүүлэхээс гадна Зөвлөлийн гишүүдэд аналитик дүн шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлдэг.

Ажлын алба нь стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Төсвийн зөвлөлийн үндсэн зорилгыг биелүүлэхэд шаардлагатай зохих ур чадвар бүхий хангалттай тооны ажилтантай байх ёстой. Ажиллах хүчний төлөвлөгөөнд Ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай ямар ур чадвартай хичнээн тооны ажилтан хэрэгтэй байгааг заана. Ажилтан бүр ямар ур чадвартай, ямар үүрэг хариуцлагатай байх тухай холбогдох тодорхойлолтыг тусгасан байна.

Ажиллах хүчний төлөвлөгөө нь одоогийн хүчин чадал болон богино-дунд хугацаанд чадавхийг бэхжүүлэх (шинээр ажилд авах, гэрээгээр ажилтан ажиллуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах гэх мэт) стратегийг тодорхойлсон байх ёстой.

- ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ Ажлын албаны ажиллах хүчний төлөвлөгөө

3. Зөвлөлийн гишүүд ба Төсвийн зөвлөлийн Ажлын албаны ёс зүйн шаардлагууд

<p>Стратеги төлөвлөгөөний Үнэт Зүйлийн тодорхойлолтонд үндэслэн ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ нь Зөвлөлийн гишүүд болон Ажлын албаны ажилтнуудын дагаж мөрдөх Ёс зүйн дүрмийг бэлтгэж, ажил үүргээ гүйцэтгэх явцдаа баримтлах ёс зүйн стандартыг тогтооно. Үүнд дүн шинжилгээ хийх явцдаа Төсвийн зөвлөлийн ашигласан хувийн эсвэл эмзэг мэдээллийг хэрхэн хэрэглэх хувь хүний үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна.</p> <p>Төсвийн зөвлөлийн Ёс зүйн дүрмийг төрийн албан хаагчдын баримталдаг ёс зүйн аливаа дүрмээс бууруулан тогтоож болохгүй. Зөвлөлийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг бэхжүүлэхийн тулд Төсвийн зөвлөлийн ёс зүйн дүрмийг илүү дээгүүр стандарттай тогтоох нь зохистой.</p>				<ul style="list-style-type: none"> • ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ Ёс зүйн дүрэм
4. Түншлэлийг бэхжүүлэх				
<p>ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ нь өөрийн чиг үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бүтээлчээр ажиллах ерөнхий зохицуулалтыг тодорхойлсон байх шаардлагатай. Гол түншүүдтэй (Үйлчлүүлэгчид, хамтран ажиллагчид, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд) хамтран ажиллах харилцаагаа тодорхойлох нь Төсвийн Зөвлөлд үйл ажиллагаагаа явуулах таатай орчныг бүрдүүлнэ. Оролцогч талуудын зураглал хийх замаар гол түншүүдийг тодорхойлж болно.</p> <p>Төсвийн зөвлөлийн гол түншүүдтэйгээ харилцах харилцааг зохих арга хэрэгслүүдийг ашиглах замаар тодорхой болгоно. Үүнд Санамж бичиг, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Журам дүрэм гэх мэт.</p>		<p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #5)</p> <p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #2)</p>		<ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудын зураглал • Гол түншүүдтэй хийсэн гэрээ (Санамж бичгүүд/ Үйлчилгээ үзүүлэх гэрээ/ Дүрэм журам гэх мэт)

<p>Жишээлбэл Мэдээлэл солилцох тухай Санамж бичгийг ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ ба салбарын гол яамуудтай байгуулснаар дүн шинжилгээ явуулахад Төсвийн Зөвлөлд шаардлагатай өгөгдөл мэдээллийн урсгалыг зохицуулахад дөхөмтэй.</p> <p>Хоёр талын харилцан байгуулсан эдгээр гэрээг байгуулснаар хувь хүний эсвэл нууц мэдээллийн нууцлалыг хамгаалах Иргэн хүний үүрэг, төрийн албан хаагчдын амлалт болох учраас мэдээллийн нууцлалыг хадгалах нь Төсвийн зөвлөлийн хүлээх үүрэг болно.</p>				
5. Өдөр тутмын үйл ажиллагаа				
<p>Дотоод үйл явц, үйл ажиллагааны журмууд нь шинээр байгуулагдсан Төсвийн зөвлөлийн байгууллагын зохион байгуулалтын гол бүрэлдэхүүн юм. Бизнес, ажлын дэс дарааллын үйл явцыг дотоод үйл ажиллагаандаа стандартжуулж, үр дүнд тууштай хүрэхийн тулд шаардлагатай байгаа дотоод үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхойлох нь чухал. Үйл явц нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих ёстой.</p> <p>Бизнес/ажлын үйл явцын стандартад дараах зүйлсийг оруулна:</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгч Төсвийн Зөвлөлөөр дүн шинжилгээ хийлгэх хүсэлт/ зөвлөгөө илгээх маягт болон журам протокол • Оролцогч талуудаас хүлээн авсан дүн шинжилгээ хийлгэх хүсэлт/зөвлөгөөг бүртгэх, эрэмбэлэх журам протокол 		<p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #1)</p>		<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны гарын авлага

<ul style="list-style-type: none"> • Төсвийн Зөвлөлийн хийсэн дүн шинжилгээ тус бүрийг эцэслэн дуусгах стандартжуулсан дотоод үе шат, алхамууд (Дүн шинжилгээ хийлгэж хүсэлтийг хүлээж авахаас эхлэн эцсийн гол бүтээгдэхүүнийг хэвлэлд бэлтгэн нийлүүлж, бүтээлийг тарааж эхлэх) • Дүн шинжилгээ хийх эрэлт хэрэгцээг бүтээлчээр хангахын тулд төрөл бүрийн бүтээлийг эцэслэн боловсруулахад зарцуулах цаг хугацаа, оруулах хувь нэмэр, орцыг тодорхойлсон цаг бүртгэлийн журам, протокол • Төсвийн зөвлөлийн аналитик шинжилгээний бүтээлд тавигдах загварын удирдамж (инфографикийн ашиглалт гэх мэт) • Хэвлэх журам; ба • Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах журам. <p>Дотоод үйл явцыг Үйл ажиллагааны гарын авлагад албан ёсоор томъёолж, кооджуулсан байдаг.</p>				
6. Аналитик ажлын арга хэрэгсэл ба аргачлал				
<p>Стратеги төлөвлөгөөнд дэлгэрэнгүй дурдсан эцсийн бүтээл нь Төсвийн зөвлөлийн төвлөрөх аналитик дүн шинжилгээний арга хэрэгсэл, аргачлалыг дэлгэрэнгүй зааварчилсан байна. Тухайн эцсийн бүтээлтэй холбоотой судалгаа хийх, шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах зохих хүрээг боловсруулах талаар ч мөн заасан байна.</p>		<p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #3)</p> <p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #4)</p>		<ul style="list-style-type: none"> • Аналитик ажлын протокол (Арга хэрэгсэл ба аргачлал)

<p>Аналитик дүн шинжилгээний зарим арга хэрэгсэл, аргачлалууд нь гуравдагч этгээдийн өгөгдөл мэдээллийн багц, программ хангамж болон нэгдсэн мэдээллийн системийг (dashboard, мэдээллийн портал гэх мэт) ашиглахыг шаардах тохиолдол бий.</p>				
7. Нөлөөллийн талаарх тайлан				
<p>Төсвийн Зөвлөл нь өөрийн ажлын үр нөлөөг хэмжиж, гүйцэтгэлийг үнэлж дүгнэдэг тогтсон арга барилтай байх ёстой. Үүнд хэрэгжүүлж буй ажлын үр нөлөөг тодорхойлох, зорилт дэвшүүлэх, өөрчлөлтийн онолтой холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулсан эсэхийг баталгаажуулах, зорилтыг биелүүлж буй эсэхи талаар тогтмол хугацаанд явцын үнэлгээ хийх зэрэг арга барилыг тусгана. Эдгээрийг жилийн ажлын тайланд тусгаж вебсайтаа байршуулах бөгөөд УИХ, Засгийн газар, Монгол Банкинд илгээнэ.</p> <p>Монгол улсын Төсвийн зөвлөлийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх хөндлөнгийн хараат бус механизмыг бий болгох нь зүйтэй. Хөндлөнгийн үнэлгээ хийхдээ зөвлөх ажилтан ажиллуулах, эсвэл байнгын зөвлөх панел/зөвлөл ажиллуулах эсвэл тогтсон үйл ажиллагаатай өөр Төсвийн зөвлөлийн мэргэжил нэгт нөхдүүдээр үнэлж дүгнүүлэхийн аль нэг хэлбэрээр хийж болно.</p>				<ul style="list-style-type: none"> • Мониторинг ба Үнэлгээний Стратеги

Үйл ажиллагаа	Хариуцан эзэн	RETF-н оруулах хувь нэмэр (2019-2020 оны ажлын төлөвлөгөөний дагуу)	Хугацаа	Эцсийн бүтээгдэхүүн/ Үр дүн
Агуулга				
<p>Үйл ажиллагааны гарын авлага нь Хараат бус Төсвийн Зөвлөлийн контекст агуулга, орц, үйл явцыг тусгасан байна (Үүнд үйл ажиллагааны зохион байгуулалтыг дэлгэрэнгүй дүрсэлнэ). Түүнчлэн Төсвийн Зөвлөлийн дүрэм, журмыг шаардлагатай тохиолдолд олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан шинэчилж болно. Ингэснээр Төсвийн Зөвлөлийн гол эцсийн бүтээгдэхүүнд нөлөөлөх юм.</p>		Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #1)		
Орц				
<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агентлагуудын түүхий эдийн үнийн мэдээллийн сан болон бусад чухал мэдээлэлд нэвтрэх эрхийг олж авах, тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах.</p> <p>DAVA Comment – Мичийн хэлснээр ОУСБ-уудын бүх өгөгдөл мэдээллийг авах боломжтой учраас энэ байх шаардлагатай гэж би бодохгүй байна. Монгол Банк, Сангийн Яам болон бусад дотоодын өгөгдөл мэдээллийн</p>		Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #5)		

<p>эх сурвалж байгууллагууд илүү чухал бөгөөд тэдэнтэй Санамж бичиг байгуулах хэрэгтэй.</p> <p>Аливаа гуравдагч этгээдийг өгөгдөл нь ОУВС, Банк гэх мэт олон улсын санхүүгийн байгууллагуудад байх бөгөөд төрийн домайнээс ч харах боломжтой байх. Шинжээчид жил бүр хялбархан ороод харчихдаг гуравдагч этгээдийн өгөгдөл мэдээллийг байршуулсан урьдчилан төсөөлөх тооцооллын аргачлалыг боловсруулах нь чухал.</p> <p>DAVA Comment – Мөн Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ялангуяа ажиллах хүчийг бусдаас гэрээгээр авах зохицуулалт, ур чадвартай хүмүүсийг татах нь нэн тэргүүний анхаарах асуудлын нэг. Эдгээртэй холбоотой үйл ажиллагааг бид яаж санал болгох вэ?</p>				
<p>Гол оролцогч талуудтай Санамж бичиг/Үйлчилгээ үзүүлэх гэрээ/ дүрэм журам, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох тохиролцоо, гэрээ.</p> <p>Энэ нь Төсвийн Зөвлөлийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал урьдчилсан нөхцөл юм.</p>		<p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #2)</p>	<p>7-р сар</p>	
<p>Үйл явц</p>				

<p>Хараат бус Төсвийн Зөвлөлийн үйл ажиллагааны гарын авлага эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг боловсруулахдаа үйл ажиллагааны зохион байгуулалтыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Төсвийн Зөвлөлийн дүрэм журмыг шаардлагатай тохиолдолд олон улсын тэргүүн туршлагад үндэслэн шинэчилж болно)</p> <p>Үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулахдаа хэд хэдэн ажлыг хэрэгжүүлсэн байх нь зүйтэй. Үүнд Ажлын албаны журам/Санамж бичиг/ засаглал, ёс зүйн дүрэм/тайланг хэрхэн танилцуулах талаар харилцан зөвшилцөж тохиролцох/ тайланг хэвлэх журам протокол зэргийг эцэслэн тохирсон байх ёстой. Ийм учраас эдгээр ажлуудыг эрэмбэ дэс дараатайгаар төлөвлөх нь зүйтэй.</p> <p>DAVA Comment – Хэрэг эрхлэх газрын ажилчдын тоог хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг нь гол бэрхшээл юм. УИХ-ын Хэрэг Эрхлэх Газрын удирдах ажилтнуудад энэ талаар хэрхэн ойлгуулах вэ? Ямар арга ашиглах вэ? Чиг үүргийн хяналт ашиглах уу?</p>		<p>Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #1)</p>		
Гарц				
<p>Дүн шинжилгээний арга хэрэгсэл ба аргачлалыг боловсруулах: (i) Эдийн</p>		<p>Зөвлөх үйлчилгээ</p>	<p>9-р сар</p>	

<p>засгийн болон төсвийн үзүүлэлтийг богино, дунд хугацаанд төсөөлөн тооцоолох Макро Төсвийн Моделинг боловсруулах, (ii) Эдийн засгийн моделинг, үнэлгээ хийх программ худалдан авах, (iii) Мэдээллийн нэгдсэн систем бий болгож, боловсруулах (dashboard, дүн шинжилгээ, мэдээлэл, интерактив)</p> <p>DAVA Comment – Одоогоор тэд программ худалдан авахад мөнгө зарцуулалгүйгээр Excel-н моделинг ашиглаж болно. Түүнчлэн үнэгүй ашиглах боломжтой моделингийн хэд хэдэн хувилбарууд бий.</p> <p>Энэ нь Төсвийн Зөвлөлд чухал учраас нэн тэргүүний чухал ажил гэж тооцож болно.</p>		(Ажлын төлөвлөгөөний #3)		
<p>Төсвийн Зөвлөлийн дүн шинжилгээ, судалгаа, зөвлөмж гаргахад тохирох хүрээг боловсруулах</p> <p>Энэ нь журамд заасан Төсвийн Зөвлөлийн үндсэн чиг үүрэг, зорилгод тулгуурлана.</p>		Зөвлөх үйлчилгээ (Ажлын төлөвлөгөөний #4)		

Хавсралт II

Журам ба Санамж бичгийн төсөлд өгөх дэлгэрэнгүй санал

Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн тухай Журмын төсөл

Энэ бол хамгийн чухал баримт бичиг бөгөөд бусад гурван чиглэлд гол нөлөөтэй юм. Журам/дүрмийн зарим зүйл заалтанд өөрийнхөө санал, тайлбарыг өглөө -

- **Журмын 2.3:** Орчуулгын алдаа ч байж болох юм. Гэвч Төсвийн Зөвлөлд төсвийн зарцуулалтын хүсэмжит гурван үр дүн болох - төсвийн сахилга бат, стратегитай хуваарилалт, үйл ажиллагааны үр ашиг зэргийг багтаасан маш өргөн хүрээтэй эрх мэдлийг олгож байгаа мэт харагдаж байна. Энэ нь Төсвийн Зөвлөл болон УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны эрх мэдлийн давхцыг шууд бий болгоно гэсэн үг. Ер нь олон улсын санхүүгийн хоёр байгууллагатай хамтарсан экосистемтэй бол Төсвийн Зөвлөл нь төсвийн сахилга бат, УИХ-ны Төсвийн байнгын хороо нь Стратегитай хуваарилалт, үйл ажиллагааны үр ашигт төвлөрөх нь зохистой. Төсвийн сахилга бат нь төсвийн урьдчилсан төсөөлөл, тухайн төсөөллийг тооцож гаргасан таамаглалын үнэн зөв байдалд тулгуурлах бөгөөд төсөв нь төсвийн холбогдох дүрэм, төсвийн тогтвортой байдлын шаардлагыг (өрийн асуудал гэх мэт) дагаж мөрдсөн эсэхийг баталгаажуулах зэргийг хамарна.
- **Журмын 2.4:** Төсвийн Зөвлөл бүх хуулийн төсөвт үзүүлэх нөлөөллийг хянахыг та хүсэхгүй байгаа биз. Ингэвэл захиргааны зохицуулалтын хувьд хүнд байдалд орно. Төсвийн Зөвлөл нь тухайн хэлэлцэж буй хуулийн төсөл батлагдвал төсөвт дунд зэргээс их нөлөө үзүүлэх магадлалтай эсэхийг үнэлэх, хэрэв тийм нөлөө үзүүлэхээр бол тухайн хуулийн төслийн өртөг/үр дагаврын бүрэн дүн шинжилгээ хийх гэж би томъёолмоор санагдаж байна. Бодит томъёоллоор төсөвт хамгийн ихээр нөлөө үзүүлдэг зүйл нь хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өртөг зардал байдаг учраас ийм хэлбэрийн дүн шинжилгээ нь тухайн хуулийн төслийн өртөг зардлыг тооцоход чиглэдэг. Үнэндээ энэ ажлыг УИХ-ын Төсвийн Хороо хийх ёстой ажил юм. Түүнчлэн Төсвийн Зөвлөлийн Ажлын албанд ажиллах ргоху загварчлалын чиглэлээр мэргэшсэн ажилчдын орон тоог ихээр нэмэгдүүлэх шаардлагатай болно.
- **Журмын 2.6** Хэрэв Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд байгаа бол энэ хэрэгтэй юу? Энд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг холбож дурдаад болно гэж бодож байна. Энэ тохиолдолд төсвийн дүрмийг өөрчилвөл журамд өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.
- **3-р бүлэг "Зөвлөлийн хурал":** Энэ нь аливаа йл ажиллагааны гарын авлагад нөлөөлөх тул Үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулахаас өмнө боловсронгуй болгох хэрэгтэй. Төсвийн Зөвлөл нь хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн гишүүдэд хэрхэн тарааж танилцуулах, ёс зүйн дүрэм / ашиг сонирхлын зөрчлийн талаар ямар дүрэм баримтлах талаар 3-р Бүлэгт дурдаагүй байна. Жишээлбэл, Засгийн газраас Төсвийн Зөвлөлд ажиллахаар томилогдсон гишүүн засгийн газраас бэлтгэсэн төсвийн төсөөллийг хянах ёсгүй. Мөн Монгол Банкнаас томилогдсон Төсвийн Зөвлөлийн гишүүн инфляцын талаарх аливаа тайлан/мэдээ, эсвэл мөнгөний бодлоготой холбоотой тайлан мэдээг хянах ёсгүй. Журмын 3.3.4-т Төсвийн Зөвлөлийн вэбсайтад Төсвийн Зөвлөлийн тайланг цахим хэлбэрээр нийтэд ил тод байршуулан танилцуулах ёстой. Энэхүү Журамд заасан цаг хугацаа маш сайн байна!
- **5-р бүлэг:** Төсвийн Зөвлөл нь өөрийн ажлын албаны боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж ажлын албаны ажилтанг шууд сонгон шалгаруулж ажилд авч болох

заалтыг 5-р Бүлэгт оруулах саналтай. Ажлын албаны ажилчид дүн шинжилгээний суурь ажлыг хийх, тайлан бичих зэрэг маш их ажлын ачаалалтай байх учраас Зөвлөл өөрөө удирдан чиглүүлж, ажлын чанарт хяналт тавих нь зүйтэй гэж бодож байна.

- **Журмын 5.3** нь Төсвийн Зөвлөл болон УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны ялгааг заагийг бүдэгрүүлж болзошгүй байна. Ингэснээр Төсвийн Зөвлөлийн хараат бус бие даасан байдалд нөлөөлнө. Богино хугацаанд Ажлын албанд боловчин хүчний хэрэгцээ ихсэхэд УИХ-ын Төсвийн байнгын хорооноос дэмжлэг үзүүлж ажилладаг гэдгийг би мэдэх боловч УИХ-аас тус Ажлын албыг зохих боловсон хүчнээр хангах ёстой. Энэ нь Төсвийн Зөвлөлийн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдалтай шууд холбоотой юм.

MoC Монгол Банк & MoC СЯ

Тодорхойлон зааснаас бусад тохиолдолд доорхи тайлбарууд нь харилцан ойлголцлын санамж бичигтэй холбоотой болно.

- Төсвийн Зөвлөл нь мэдээлэл, баримт бичиг эсвэл өгөгдөл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаар Санамж бичигт дурдаагүй байна. Дор дурдсан агуулгыг тусгасан тусгай бүлэг байх ёстой:
 - Төсвийн Зөвлөл мэдээлэл авах хүсэлт хэрхэн гаргаж, мэдээллийг хэрхэн яаж дамжуулдаг?
 - Тухайн байгууллагын хэнд нь хандаж хүсэлтээ гаргах вэ?
 - Өдөр тутмын үйл ажиллагаанд хүсэлтийн талаар Төсвийн Зөвлөлтэй харилцаж ажиллах асуудлыг хэн хариуцах вэ? (жишээ нь тухайн байгууллагын мэдээллийн ажилтан уу эсвэл Төсвийн Зөвлөлтэй харилцах асуудал хариуцсан тусдаа ажилтан уу)?
 - Төсвийн Зөвлөлд мэдээллийг хэрхэн танилцуулах вэ?
 - Төсвийн Зөвлөлд илгээх мэдээллийн формат загвар ямар байх вэ? (жишээ нь Санамж бичигт тайланг Word файлаар, өгөгдлийг холбогдох форматаар Төсвийн Зөвлөлийн системд нийцүүлэн Excel гэх мэт хувиргах боломжтой форматаар өгөгдлийг илгээнэ гэж зааж өгөх ёстой).
- Тухайн байгууллага Төсвийн Зөвлөлийн хүсэлтэнд хариулах боломжтой цаг хугацааны талаар Санамж бичигт тусгах нь зүйтэй.
- Төсвийн Зөвлөлд шаардлагатай мэдээллийн ихэнийг жил бүр гаргадаг. Иймд 2-р Бүлгийн "Ерөнхий хүрээнд" жил бүр эсвэл тогтсон хугацаанд гаргадаг мэдээлэл, тайлан, дүн шинжилгээ, өгөгдлийг ялгаатай тодорхойлж, эдгээр мэдээллийг Төсвийн Зөвлөлд автоматаар илгээхийг шаардах нь зүйтэй. Үүнийг одоогийн төсөлтэй ижил байдлаар жагсааж заах хэрэгтэй. Төсвийн Зөвлөл нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хийж буй хөндлөнгийн хараат бус дүн шинжилгээнд шаардлагатай гэж үзсэн бусад байгууллагын аливаа мэдээлэл, баримт бичиг, өгөгдлийг авч ашиглах эрхийг олгосон нэмэлт заалт оруулах хэрэгтэй.
- Хэрэв аливаа байгууллага тухайн мэдээлэл / өгөгдлийн (тухайлбал, төрийн нууц / аюулгүй байдлын үндэслэлээр) нууцлалыг хадгалах эсвэл гүйцэтгэх давуу эрхтэй бол эдгээр үндэслэлийг нарийвчлан тайлбарлаж, Санамж бичигт тусгасан байх ёстой. Тухайн байгууллага мэдээллийг ямар үндэслэлээр олгохоос татгалзаж байгаагаар тодорхой тайлбарлах шаардлагатай.
- Хэрэв аливаа байгууллага нь нууцлал хадгалах / давуу эрхтэй эсвэл Төсвийн Зөвлөлийн хүсэлтэд хариу өгөхгүй байгаа тохиолдолд Санамж Бичгийн хүрээнд өөрийн бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, ямар арга хэрэгсэл ашиглах боломжтойг зохицуулсан заалт байх ёстой.
- Эдгээр үйл явц нь Журам ба Үйл ажиллагааны гарын авлагад тусгагдсан байх бөгөөд ялангуяа мэдээлэл хүссэн хүсэлтийг бэлтгэх, мэдээллийг ирүүлэхтэй холбоотой үйл явц, алхамуудыг Үйл ажиллагааны гарын авлага боловсруулахаас өмнө боловсронгуй болгох хэрэгтэй.

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХООРОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ САНАМЖ БИЧИГ**

2021 оны 3 дугаар сарын.....

Улаанбаатар хот

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нэг талаас, нөгөө талаас Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “хоёр тал” гэх) нь хамтран ажиллах талаар доор дурдсан асуудлаар харилцан тохиролцож, энэхүү санамж бичгийг үйлдэв.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Санамж бичгийн зорилго нь банк бус санхүүгийн болон даатгал, хөрөнгө, зээллэгийн зуучлалын үйлчилгээний болон хөрөнгийн ба үнэт цаасны зах зээлийн найдвартай ажиллагааг хангах зэрэг Санхүүгийн Зохицуулах Хорооны бүрэн эрхэд хамаарах үйл ажиллагааны хэвийн байдал хийгээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад хоёр тал дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2.Төсөв, сангийн бодлого, санхүүгийн тогтвортой байдлын болон төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний төсөл болон бусад хууль тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр шинжилгээ судалгаа, санал дүгнэлт, төсөөлөл хийх, онол практикийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдлэг мэдээлэл түгээх, төсвийн захирагч болон бусад холбогдох талуудын оролцоо, салбар дундын зохицуулалтыг хангах, мэргэжлийн зөвлөмж, санал дүгнэлт гаргах талаар хоёр тал харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.Хоёр талын хамтын ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 69, 83 дугаар тогтоолууд болон бусад хууль, тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний холбогдох заалтыг мөрдлөг болгон банк бус санхүүгийн болон бусад зуучлалын үйл ажиллагааны үр ашиг, үнэт цаас хөрөнгийн зах зээлийн хөгжил болон төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, бие биедээ харилцан дэмжлэг үзүүлж, хүндэтгэлтэй хандах зарчимд тулгуурлана. Төсөв, санхүүгийн салбарт гарч болох аливаа эрсдлийн талаар аль нэг талын санаачилсан санал, зөвлөмжийг хамтран хэлэлцэж, шаардлагатай бол холбогдох байгууллагын анхааралд оруулна.

1.4.Банк бус санхүү болон бусад үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нь төсвийн тогтвортой байдлыг хангах, татвар төлөгчдөд эрсдэл үүсгэхгүй байхад чухал нөлөөтэй болохыг хоёр тал хүлээн зөвшөөрч, энэ талаар хамтран ажиллахаа эрхэм зорилго болгоно.

1.5.Энэхүү санамж бичиг нь хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**ХОЁР.ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ
ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.1.Хамтын ажиллагаа нь Төсвийн болон санхүүгийн тогтвортой байдалд хамааралтай энэхүү санамж бичгийн нэгдүгээр зүйлд заасан зорилт, ажлын чиглэлийг хангахад бодлого төлөвлөлт, хэрэгжилт, мониторингийн асуудлуудаар хоёр тал санал солилцож, шаардлагатай гэж үзвэл аливаа асуудлаар шинжилгээ судалгаа хийх, онол практикийн хурал зохион байгуулах, мэргэжлийн зөвлөмж, санал дүгнэлт гаргах, холбогдох

байгууллагууд, иргэдэд сурталчлан таниулах зэргээр үр дүнтэй хамтран ажиллахад чиглэгдэнэ.

2.2. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо нь банкнаас бусад санхүүгийн зах зээлийн талаарх хавсралт №1-д дурдсан мэдээллээр тухай бүрт хангаж ажиллана.

2.3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь улс орны эдийн засаг, санхүү, төсвийн талаар боловсруулсан санал, дүгнэлтийг тухай бүр нь Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлж байна.

2.4. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлын талаар хийгдсэн шинжилгээ, дүгнэлт;

2.5. Санхүүгийн зохицуулах хорооны ашигладаг олон улсын мэдээлэл, сайтуудаас хөрөнгийн зах зээлийн олон улсын зарим зах зээл мэдээлэл болон дэлхий дахины болон бүс нутгийн эдийн засаг, санхүүгийн байдлын тухай мэдээллийг тохирсон загвар, хэлбэрээр тодорхой хугацаанд харилцан солилцож байх;

2.5. Дээрх мэдээлэл, тоон мэдээг шуурхай авах үүднээс заавал албан бичиг шаардахгүйгээр цахим шуудангийн хэлбэрээр тухай бүр харилцан авч болно.

2.6. Хоёр тал хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажлын эмхтгэл, ном, товхимлыг харилцан солилцож байна.

2.7. Монгол Улсын хөрөнгийн, даатгалын, санхүүгийн зах зээлийн судалгаа шинжилгээний ажлыг хамтран гүйцэтгэж болно.

2.8. Хамтын ажиллагаанд хамаарал бүхий аль нэг талын зохион байгуулж байгаа гадаад, дотоод аргах эмжээ, сургалт семинар, танилцах аялалд талуудын төлөөллийг оролцуулж болно.

ГУРАВ.БУСАД ЗҮЙЛ

3.1. Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын алба, Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газар тус тус хариуцан зохион байгуулах бөгөөд үр дүнг хагас жил тутам тайлагнана. Талууд хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган үр дүнг Зөвлөлийн хурал болон Санхүүгийн зохицуулах хорооны захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулан хагас жил тутамд хамтарсан уулзалт зохион байгуулж ажлын үр дүнгээ дүгнэнэ.

3.2. Санхүүгийн зохицуулах хорооноос Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлсэн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд олон нийтэд зориулагдаагүй мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

3.3. Мэдээлэл хүргүүлж буй тал нь мэдээллийн нууцлалын зэрэглэлийг тогтоох эрхтэй, харин мэдээлэл хүлээн авагч тал нь уг мэдээллийг зөвхөн албан зориулалтаар ашиглана.

3.4. Энэхүү санамж бичгийг тус бүр 2 хувь үйлдэн талуудад хадгалуулав.

Санамж бичиг байгуулсан:

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг төлөөлж:

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга

Д.Даваасамбуу

Санхүүгийн зохицуулах хороог төлөөлж:

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

Д.Баярсайхан